



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын
2019 оны 2 дүгээр сарын 26-д
ТООТ ТУШААЛЫН ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

**СУУРЬ БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ХЭЛ, ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ,
МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ФИЗИК БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ,
ТҮҮХ, НИЙГЭМ СУДЛАЛ, ДҮРСЛЭХ УРЛАГ, ХӨГЖИМ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИ,
БИЕИЙН ТАМИР, АНГЛИ ХЭЛ, ОРОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН САЙЖРУУЛСАН
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Суурь боловсрол VI-IX анги)

Улаанбаатар
2019



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МОНГОЛ
ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Суурь боловсрол VI-IX анги)

Улаанбаатар
2019

“Монгол хэл, бичиг”-ийн сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч: Ш.Оюунцэцэг, БМДИ-ийн Хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургалтын албаны дарга

Монгол хэл

Б.Оюунцэцэг Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
Ө.Цэндсүрэн Нийслэлийн Боловсролын газрын ахлах мэргэжилтэн
М.Базаррагчаа Монгол Улсын Их сургууль, НХУС-ийн багш проф. Sc.D
Ц.Өнөрбаян Монгол Улсын Боловсролын Их Мургууль, МоСС-ийн профессор багш, Sc.D
Ц.Туул “Шинэ эрин” лаборатори сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
Б.Цасанчимэг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Ш.Баттөгс Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХУС-ийн тэнхимийн эрхлэгч, Ph.D
Д.Эрдэнэсан Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХУС-ийн багш, Ph.D

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Ө.Цэндсүрэн Singapore School of Mongolia сургуулийн захирал, магистр
Ш.Оюунцэцэг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Сургалтын албаны дарга, магистр
Д.Эрдэнэсан Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХУС-ийн багш, Ph.D
Б.Цасанчимэг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Г.Нандинбилиг Монгол Улсын Их Сургууль, ХШУС-ийн багш, Ph.D
П.Одсүрэн Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, Ph.D
Ц.Туул “Шинэ эрин” лаборатори сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
А.Энхнаран “Байгаль эх” лицей сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
Л.Цэдэнсодном Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр
Ж.Гэрэлмаа Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

VI АНГИ МОНГОЛ ХЭЛ

УНШИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>6.1а. Алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, үйл явдлын мэдээ зэрэг эхийн орон, цагийн дараалал, учир шалтгааны уялдаа холбоо, бүтцийг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таних</p>	<ul style="list-style-type: none"> • Эхэд юуны тухай гарч байгааг ярилцах • Хэдэн санаа бүхий үйл явдал гарч байгааг жагсаах • Үйл явдлууд эхийн аль хэсэгт хамаарч байгааг зааглах • Үйл явдлууд болсон цагийн дарааллыг илрүүлэх • Үйл явдал ямар дарааллаар өрнөдөг талаар мэдэх (Үйл явдал /цагийн нэрээр, цагийн утгат өгүүлбэрээр, дараалал заасан холбох үгээр, өгүүлбэр хооронд зэрэгцүүлэн хобохын 1-р бүлгийн нөхцөлөөр тус тус илэрнэ.) • Үйл явдал хэзээ, хаана, болов? гэдгийг ярилцах • Учир шалтгааны асуултад хариулах • Хариултаа ашиглан учир шалтгааны холбоо хамаарлыг гаргаж бүдүүвч хийх, тайлбарлах • Бичигчийн хэлэх гэсэн гол санаа аль хэсэгт, ямар үг өгүүлбэрээр илэрснийг олж тэмдэглэн тайлбарлах • Хүүрнэмж эхээс бичигчийн мэдрэмж, сэтгэгдэл, хэрэглэсэн уран дүрслэл, нэмэлт утга илэрхийлсэн үг, бүтээврийг ялгаж, өнгө аясыг тодорхойлох • Сэдэв, гол санаа, үйл явдлын дараалал, өнгө аяс нь хүүрнэмж эхийн үндсэн шинжүүд болохыг мэдэх 	<p>Монголын уран зохиолын дээжис, Цаасан шувуу-1, Боть 107, 108</p> <p>Анне Франкийн өдрийн тэмдэглэл, Уб., 2011</p> <p>Монгол домог үлгэр</p> <p>Хөгжөөнтэй туужууд</p>
<p>6.1б. Богино өгүүлэг, үлгэр зэрэг эхийн бүтэц, учир шалтгааны уялдаа холбоо, орон цагийн дарааллыг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таних</p>	<ul style="list-style-type: none"> • Эхэд юуны тухай гарч байгааг ярилцах • Хэдэн санаа бүхий үйл явдал гарч байгааг жагсаах • Үйл явдлууд эхийн аль хэсэгт хамаарч байгааг зааглах • Үйл явдлууд болсон цагийн дарааллыг илрүүлэх • Үйл явдал ямар дарааллаар өрнөдөг талаар мэдэх (Үйл явдал /цагийн нэрээр, цагийн утгат өгүүлбэрээр, дараалал заасан холбох үгээр, өгүүлбэр хооронд зэрэгцүүлэн хобохын 1-р бүлгийн нөхцөлөөр тус тус илэрнэ.) • Үйл явдал хэзээ, хаана, юунаас болж /зангилаа/ үйл явдал цааш өрнөв? гэдгийг олох • Түлхүүр үг, хэллэг ашиглан тулгуур бичиглэл хийх • Үйл явдал хэрхэн төгсөж байгааг ажиглах • Зангилаа болон төгсгөлийн хамаарлыг тогтоох • Хүүрнэмж эхийн үйл явдал нь эхлэл, зангилаа, өрнөл, төгсгөл гэсэн дарааллаар өрнөдгийг ойлгох • Сэдэв, гол санаа, үйл явдлын бүтэц, дараалал нь хүүрнэмж эхийн үндсэн шинж болохыг мэдэх <p>Багшид зөвлөх нь Хүүрнэмж гэдэг нь аливаа үйл хэрэг, явдлыг цаг хугацааны дарааллаар өгүүлэх зохиомж юм. Хүүрнэмж эхийн бүтэц</p>	<p>М.Базаррагчаа нар, Монгол хэл VI, сурах бичиг, 2006</p> <p>Ц.Өнөрбаян нар, Монгол хэл VI, сурах бичиг</p>

	<p><i>гэдэгт эхлэл, зангилаа, өрнөл, төгсгөлийг хамааруулж ойлгоно.</i></p> <p><i>Үйл явдлын дараалал гэдгийг орон ба цаг хугацааны дараалал гэж ойлгох ба тэдгээрийг илрүүлэх хэлний ойлголтуудыг судалж, хэрэглэнэ.</i></p> <p><i>Хүүрнэмж эхийн үйл явдлын бүтэц нь эхлэл, зангилаа, өрнөл, төгсгөлөөс бүтдэгийг ойлгуулна. Үйл явдлын туйл, тайлал гэх мэтээр хүндрүүлж заахгүй. Учир нь монгол хэлний хичээл дээр эхлэл, зангилаа, өрнөл, төгсгөлийг л ялган таньдаг болоход анхаарна. Үйл явдлын эхлэл, гол, төгсгөл хэсгийн талаар бага ангидаа судалсан байгаа учраас нэмж зангилаа гэж юу вэ? гэдгийг ойлгуулна. Тэгэхдээ зөвхөн юунаас болж? гэдэг асуултаар шалтгаануудыг тодруулах, олон шалтгаануудаас аль нь үйл явдал өрнөх шалтгаан болж байна гэдгийг ярилцуулж, шийдэх замаар ойлголттой болгоно. Дараа нь хүүрнэмж эх зохион бичихдээ үйл явдлын зангилаа үүсгэж, тэрнээсээ үйл явдлыг өрнүүлж сурна гэсэн үг.</i></p> <p><i>Нөгөө талаар хүүрнэмж эхийн хамгийн гол шинж бол үйл явдал нь цагийн дарааллаар өрнөдөг. Тиймээс үйл явдлын дарааллыг ойлгуулахдаа цагийн нэр, цагийн дараалал заасан холбох үг, нөхцөлдүүлэн холбохын 1-р бүлгийн нөхцөлүүдийг зөв хэрэглэж сурахад анхаарна.</i></p>	
<p>6.1в. Хүүрнэсэн эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн уялдаа холбоог тогтоож, эхийн сэдэв, гол санааг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> • Уншихын өмнө эхийн нэр, дэд гарчиг, эхний ба сүүлийн өгүүлбэр, бүтцийн аль нэг хэсэг зэргээс утгыг таамаглах • Мөн ямар нэг тайлбар, зураг байгаа эсэхийг сайн хар. Энэ нь эхийн утга агуулгатай ямар холбоотой болохыг ярилцах • Уншихдаа танил бус үгийн доогуур зурж тэмдэглэх • Шинэ үгийн санг унших - тайлбарлахдаа хам сэдвээс утгыг таамаглах, толь бичиг ашиглах • Түлхүүр үгийг олох - тухайн эхийн утгыг гаргахад онцгой үүрэг гүйцэтгэсэн үгсийг тэмдэглэх • Түлхүүр үгээ ашиглан холбоо хамаарлыг харуулсан бүдүүвч хийх • Эхэд хэдэн үйл явдал гарч байгаагаар нь цогцолбор болгох • Цогцолбор тус бүрт өгүүлэгдэж байгаа юмыг тодорхойлох • Цогцолбор тус бүрт ямар асуудал дэвшүүлснийг тодорхойлох • Тухайн сэдвүүдийг ажиглаж, гол сэдэв нь аль вэ? Цогцолбор тус бүрд илэрсэн туслах сэдвүүд гол сэдвийг хэрхэн дэмжсэнийг тодорхойлох • Гол сэдвийг зохиолын төгсгөл хэсгийн үйл явдалтай холбон гол санааг тодорхойлох • Өнгө аясыг мэдэрч, зохиолчийн хандлагыг тодорхойлох <p>Багшид зөвлөх нь: Сэдэв, гол санаа тодорхойлохдоо</p>	<p>М.Базаррагчаа нар, Монгол хэл VI, сурах бичиг, 2006</p> <p>Ц.Өнөрбаян нар, Монгол хэл VI, сурах бичиг</p> <p>Ж.Баянсан, Б.Чимгээ, Сурагчийн гарын авлага УБ, 2006</p> <p>Д.Галбаатар, Уран зохиолын нэвтэрхий толь, УБ, 2012</p>

	<ul style="list-style-type: none"> • <i>Үйл явдлын дараалал түүн дотроос төгсгөл хэсэгт анхаарлаа хандуулах</i> • <i>Сэдвийг эхийн төгсгөлийн үйл явдлаар баримжаалж, гол санааг тодорхойлох</i> <p><i>Гол сэдвийг ялгаж сургахын тулд дэмжсэн сэдвүүдийг үйл явдлын төгсгөлтэй холбож, баталж, нотлох замаар ойлгуулах зэргээр ажиллана. Өөрөөр хэлбэл хэрэв сэдэвтэй гэж үзвэл үйл явдал яаж өрнөж, яаж төгсөх вэ? гэх зэрэг чиглэлийг өөрчлөх асуултаар хөтөлж яриулна. Ингэж чиглэлийг өөрчлөх асуултаар чиглүүлснээр сурагч үйл явдал, сэдэв, гол санааны холбоо хамаарлыг илүүтэй ойлгож авна. Дараа нь өөрсдөө бичих үедээ сэдэв, гол санаандаа тохируулан үйл явдлыг сонгох, яаж төгсгөх вэ? гэдгээ мэддэг болно. Нөгөө талаар уншсан зүйлийнхээ сэдэв, гол санааг тодорхойлж сурна</i></p>	<p>Монгол ардын домог үлгэр</p> <p>Үргэлжилсэн үгийн зохиолууд</p>
<p>6.1г. Уншсан эхээс орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> • Үйл явдал хаана болж байгааг тодорхойлох • Тэр газрын төрх байдлыг яаж дүрсэлснийг тодруулах • Үйл явдал хэзээ өрнөж байгааг олох • Цаг агаар, улирлын байдлыг дүрсэлсэн хэсгийг олох • Яаж дүрсэлсэн арга хэрэглүүрийг тодорхойлох • Тухайн арга хэрэглүүрийг ашиглан бичил дүрслэл бичих • Үйл явдал өрнөсөн цаг хугацаа, газар орны дүрслэл нь сэдэв болон дүрийн шинжтэй хэрхэн холбогдож байгааг таамаглан ярилцах • Үйл явдлын орчин нь хүүрнэмж эхийн нэг шинж болохыг мэдэх 	<p>Д.Галбаатар, Уран зохиолын нэвтэрхий толь, УБ, 2012</p>
<p>6.1д. Эхийн доторх харилцан ярианы үүргийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> • Эхэд юуны тухай өгүүлснийг тодорхойлох • Ямар ямар дүр гарч байгааг ажиглах • Дүрүүд хоорондоо юу ярьсныг дахин унших • Дүрийн ямар шинж илэрч байгааг тодорхойлох • Тэдний хоорондын харилцааны өнгө аяс ямар байгааг жишээгээр тайлбарлах • Тухайн харилцан яриа нь дүр хоорондын шууд яриагаар уу, эсвэл өгүүлэгчийн яриагаар дамжиж илэрсэн үү гэдгийг ажиглах • Аль нь илүү дүрийн шинжийг тодруулахад үүрэгтэй, аль нь үйл явдлыг нуршилгүйгээр илэрхийлэхэд нөлөөлж байгааг тайлбарлах <p>Багшид зөвлөх нь: <i>Харилцан яриа нь хүүрнэмж эх, тэр тусмаа өгүүллэг үлгэр, домог зэрэг уран зохиолын хүүрнэсэн эхэд онцгой үүрэгтэй.</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>Дүрийн шинжийг тодруулахад нөлөөлнө</i> • <i>Үйл явдлыг нуршилгүйгээр шууд харуулах зорилгоор хэрэглэдэг гэдгийг сурагчдад ойлгуулах ба уран зохиолын хүүрнэсэн эх зохиохдоо харилцан яриа оруулж бичих, цэг тэмдгийг зөв хэрэглэж сурахад анхаарна.</i> 	<p>Н.Нарантуяа нар, Бичих чадварыг бүтээлчээр хөгжүүлэх нь, УБ., 2014</p>

<p>6.1е. Уншсан эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялгаж, зохиогчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> • Эхэд юуны тухай өгүүлснийг тодорхойлох • Эхийн гол санааг түлхүүр үг, хэллэг, өгүүлбэрийг олох замаар тодорхойлох • Эхээс бичигчийн болон дүрийн сэтгэгдэл, мэдрэмжийг ялгах • Өнгө аяс нь таатай, таагүй алин эсэхийг ярилцаж, шалтгааныг тайлбарлах • Ямар үг хэллэг, дүрслэл ашиглаж, мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлснийг тайлбарлах • Сэтгэгдэл, мэдрэмжийг эхийн гол санаатай холбон тайлбарлах <p>Багшид зөвлөх нь: <i>Мэдрэмж, сэтгэгдэл, сэтгэл хөдлөлийг дүрслэн бичих хэлний арга хэрэглүүрийг сайн ажиглуулаарай. Ингэх нь үгийн баялгийг нэмэгдүүлэх, дүрслэн бичих чадварыг хөгжүүлэхэд тустай. Мөн хүүрнэмж эх бол тэр чигээрээ дүрслэл байдгийг танин мэдүүлэх нь чухал.</i></p>	<p>Анне Франкийн өдрийн тэмдэглэл, УБ.,2011</p> <p>Алдартай захидлууд</p>
<p>6.1ж. Уншсан эхээс чухал хэсгийг олж, бичигчийн санааг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> • Уншихдаа танил бус үгийн доогуур зурж, тэмдэглэн, утгыг нь хам сэдвээс эсвэл толь бичиг ашиглан тодруулах • Түлхүүр үгийн доогуур зурах. Магадгүй өөрт чинь хэрэгтэй байгаа мэдээлэлтэй холбоотой түлхүүр үг тааралдвал тэр хэсэгт анхаарлаа хандуулах • Эсвэл эхлэл хэсэг болон , төгсгөл хэсгийг унших замаар өөрт хэрэгтэй мэдээлэл байгаа эсэхээ шийдэж болно. • Мөн өөрт чинь хэрэгтэй мэдээлэл байвал аль номын хэддүгээр хуудсанд байсан, эсвэл тухайн эхийн хэддүгээр мөрөнд байсан зэргийг тэмдэглэж авах • Мөн ямар нэг тайлбар, зураг, хүснэгт, диаграмм, тоон мэдээлэл байгаа эсэхийг хар. Хэрэв байвал тэнд уг бичвэрт юуны тухай өгүүлж буй нь тодорхой харагдах болно. • Яагаад энэ мэдээлэл чамд чухал юм бэ?, юунд хэрэглэх вэ? гэдгээ тодорхой тайлбарлах 	<p>Н.Нарантуяа нар, Бичих чадварыг бүтээлчээр хөгжүүлэх нь, УБ., 2014</p>
<p>6.1з. Эхээс гол мэдээллийг нэгтгэн дүгнэж унших</p>	<ul style="list-style-type: none"> • Сэдэв тодорхойлох • Сэдэвтэй холбоотой гол гол мэдээллийг ялгах • Яагаад гол гэсэн учрыг тайлбарлах • Гол мэдээллийг батлах бусад баримтыг ялгах • Мэдээллийг уншаад дүгнэлт гаргах 	<p>Намтар, түүх</p>
<p>6.1з. Үйл явдлын мэдээ мэдээллийг нэгтгэн дүгнэж унших</p>	<ul style="list-style-type: none"> • Мэдээ, мэдээллийг унших • Сэдэв тодорхойлох • Мэдээллийг нэгтгэн дүгнэх. <ul style="list-style-type: none"> • Хүснэгтэд оруулах • Диаграмм, бүдүүвчээр харуулах • Тулгуур бичиглэл хийх • Мэдээллийг бүлэглэх • Мэдээллийг 6 асуултын дагуу хураан бичих • Тайлбарлах 	<p>Сонин, сэтгүүл, телевизийн мэдээ</p>
<p>6.1и.</p>	<ul style="list-style-type: none"> • Уншсан эхээс жинхэнэ нэрийг асуултаар ялган тэмдэглэх ба ажиглаж, утга, бүтэц хувиллыг тодорхойлох 	<p>М.Базаррагчаа нар, Монгол хэл</p>

<p>Уншсан эхэд жинхэнэ нэр, нэрийн тийн ялгал, биед ба эзэнд хамаатуулах нөхцөл, олон тооны дагаврыг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> • Жинхэнэ нэрийг утгаар нь бүлэглэх /оноосон ба ерийн/ • Бүтцээр задлан тайлбарлах • Бүтцийн зааг дээрх зөв бичих дүрмийг тайлбарлах • Ижил дүрэм бүхий үг олж бичих • Эх ба өгүүлбэрт жинхэнэ нэр болон хувиллыг нөхөж бичих • Эхээс түлхүүр үгийг түүж, жинхэнэ нэрийн үүргийг тайлбарлах • Жинхэнэ нэрийг ойролцоо утгат үгээр солин найруулж, үүргийг ярилцах • Найруулгын болон дүрмийн алдаатай бичсэн жинхэнэ нэрийг зөв болгох • Жинхэнэ нэрийн утга, бүтэц, үүргийг таниулахуйц ханын плакат, схем бүдүүвч хийж ойлголтоо харуулах • Үгийн сүлжээ хийх, бөглөх <p>Багшид зөвлөх нь: <i>Бага ангид сурагчид үгсийн аймгийг асуултаар нь таньж сурсан байх ёстой. Тиймээс дунд ангид нь асуулт, утга, бүтэц, хувиллыг мэдэж, зөв хэрэглэх, нэр томъёог хэрэглэж хэвшихэд анхаарна.</i> <i>Онолын ойлголтыг заахдаа аль мэдлэгийг зөвхөн таниулаад л өнгөрөх вэ? Алийг нь гүнзгийрүүлэн заах вэ? гэдгээ сайн бодож хичээлээ төлөвлөнө. Тэгэхдээ хэлний ойлголтыг утга, үүрэг, хэрэглээ, үгийн санг баяжуулах үйл ажиллагаатай байнга холбож заана.</i> <i>Жинхэнэ нэрийг таниулах явцад үгсийн холбооны тухай ойлгуулна. Ингэхдээ тухайн жинхэнэ нэр ямар үгтэй холбогдож байгааг олуулна. Тэгэхдээ жинхэнэ нэрийг тийн ялгалаар ялгуулна. Ялгасан жинхэнэ нэрээрээ холбоо үг үүсгэнэ. Тэндээс жинхэнэ нэр нь 8 тийн ялгалаар хувилдаг бөгөөд эдгээрээс харьяалахын тийн ялгалаас бусад нь үйл үгтэй, харьяалахын тийн ялгал л нэр үгийг нэр үгтэй холбогддог гэдгийг ажиглуулах замаар ойлгуулна.</i></p>	<p>VI, сурах бичи, 2006</p> <p>Ц.Өнөрбаян нар, Монгол хэл VI, сурах бичиг</p> <p>Ж.Баянсан, Б.Чимгээ, Сурагчийн гарын авлага УБ, 2006</p>
<p>6.1к. Уншсан эхэд үйлийн цагаар төгсгөх болон биеэр төгсгөх, тодотгон холбох болон нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэлзүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> • Уншсан эхээс үйл үгийг асуултаар ялган таних • Ялгасан үйл үгийн хувиллыг ажиглаж, хаана ямар үгтэй холбогдон, ямар утга, үүргээр орсныг тодорхойлох • Бүтцээр задлан, утга, үүргийг тайлбарлах • Хэл зүйн олон хэлбэр бүтээж, төрөл үгээс ялган тайлбарлах • Эх болон өгүүлбэрт үйл үг, үйл үгийн нөхцөлийг утгаар нь нөхөх • Нийлмэл өгүүлбэрийг энгийн болгох • Энгийн өгүүлбэрийг холбох нөхцөл ашиглан нийлмэл болгох • Зураг хараад өгүүлбэр зохиох • Тодотгон холбох нөхцөл ашиглан үйл явдлын орчны дүрслэл бүтээх 	<p>Ө.Цэндсүрэн “Бодит чадвар” 7, УБ, 2007</p> <p>Ө.Цэндсүрэн “Бодит чадвар” 6, УБ, 2007</p>

	<ul style="list-style-type: none"> • Нөхцөлдүүлэн холбох 1-р бүлгийн нөхцөл ашиглан, үйл явдлын дарааллыг харуулсан бичил эх, өгүүлбэр зохиох • Хүүрнэмж эх зохиохдоо учир шалтгааныг нөхцөлдүүлэн холбохын 2-р бүлгийн нөхцөлийг ашиглан бичих <p>Багшид зөвлөх нь: <i>Үйл үгийн нөхцөлийг таниулахдаа хүүрнэмж эхэд яаж хэрэглэсэн байна вэ? гэдэг шинжилгээг хийсний дараа, тэдгээрийг хүүрнэсэн эхэд хэрэглэхэд анхаарч ажиллана. Хэрэглэж сургахын тулд дээрх үйл ажиллагаанаас сонгон хийлгэж болно.</i> <i>Үйл үг нь эсвэл жинхэнэ нэртэй, эсвэл үйл үгтэй холбогддогийг ажиглуулах замаар таниулна. Өгүүлбэр дэх үгсийн холбоог таниулахдаа тоглоомын аргаар ойлгуулж болно.</i> <i>Тиймээс багш нар өгүүлбэр дэх үгийн хэлхээ холбоог ойлгуулахдаа үгэн гинж тоглуулж болно. Тиймээс үгэн гинж тоглохдоо:</i></p> <ul style="list-style-type: none"> • Бүх сурагч тойрог хэлбэртэй суугаад эхний хүүхэд дурын холбоо үг хэлнэ. Дараагийн сурагч тэр холбоо үгийн төгсгөлийн үгээр эхэлсэн холбоо үг хэлэх замаар тоглоно. Энэ нь сэтгэхүйн хялбар боловч хурд шаардсан тоглоом тул түгдрэхгүйгээр 3 секундын дотор амжиж холбоо үгээ нэрлэх ёстойг анхаарах хэрэгтэй. Ийнхүү түгдэрсэн сурагч хянагчийн суудалд сууж хасагдах журмаар тоглоно. <p><i>Морины нүүдлээр нүүж, холбоо үгээр өгүүлбэр бүтээж тоглохдоо тусгай бэлтгэсэн хүснэгтэн хөлөг дээр тоглоно. Үүнийг бодит чадвар 7 дээрээс хараарай.</i></p>	
<p>6.1л. Уншсан эхэд орон цагийн нэрийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэлзүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох</p>	<p>Дараах үйл ажиллагаануудыг хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Уншсан эхээс орон цагийн нэрийг асуултаар ялган таних • Эхэд ямар утга, үүргээр орсныг тодорхойлох • Утгаар нь бүлэглэх • Орон цагийн нэрээр тодорхой орон, байрлал, зүг, чиг, цаг хугацааг зааж, илэрхийлсэн харилцан яриа, эх, өгүүлбэр зохион бичих • Эх болон өгүүлбэрт орон цагийн нэрийг утгаар нь нөхөх • Цөм өгүүлбэрийг орон цагийн утгаар нэмэн дэлгэрүүлж хувиргах • Цагийн нэрийг ашиглан үйл явдлын дарааллыг харуулсан өгүүлбэр, эх зохиох • Орон цагийн нэрийг ашиглан орчны дүрслэл бүтээх <p>Багшид зөвлөх нь: <i>Хүүрнэмж эхэд орон цагийн нэр ямар утга, үүрэгтэй орж байна гэдгийг тайлбарлуулах, хэрэглэхэд анхаарна.</i></p>	<p>М.Базаррагчаа нар, Монгол хэл VI, сурах бичи, 2006</p> <p>Ц.Өнөрбаян нар, Монгол хэл VI, сурах бичиг</p>

<p>6.1н. Өгүүлбэрийг гишүүдээр хурааж, дэлгэрүүлж найруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Эхээс хэн/юу+хэнийг/юуг+ яа... ?, хэн/юу+яа...? гэсэн асуултын дагуу цөм бүтцийг ялгах • Ямар ялгааг байгааг ярилцаж олох • Эндээс өгүүлбэрийн цөм бүтэц нь юугаараа ялгардгийг ойлгох (Үйл үгийн тусах, эс тусах шинжээс хамаардаг.) • Эхээс сонгосон дэлгэрэнгүй өгүүлбэрийг цөм бүтцэд хураах • Эхийг уншаад утгыг цөм бүтцээр хураах • Эхийг уншаад цогцолборуудын утгыг цөм өгүүлбэрээр хураан бичих • Өгүүлбэрийн хураангуй бүтцийг тодотгон холбох нөхцөлтэй үйл үг, орон цагийн нэрээр дэлгэрүүлэх <p>Багшид зөвлөх нь: Өгүүлбэрийн цөм бүтцийг ойлгуулахдаа дээрх алхмын дагуу ойлгуулна. Гэхдээ маш олон цагаар зурах, цөм бүтцийг ялгах зэрэг үйл ажиллагааг хийх хэрэггүй. Харин түүнийг хэрэглээтэй холбон заах хэрэгтэй.</p>	<p>М.Базаррагчаа нар, Монгол хэл VI, сурах бичи, 2006</p> <p>Ц.Өнөрбаян нар, Монгол хэл VI, сурах бичиг</p>
--	---	---

БИЧИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>6.2а. Захидал, намтар, өдрийн тэмдэглэл, тохиолдсон явдал, үйл явдлын мэдээг орон, цагийн дарааллаар өрнүүлэн учир шалтгааны уялдаа холбоотой бичих</p>	<ul style="list-style-type: none"> • Эхэд юуны тухай өгүүлж, ямар гол санаа гаргах вэ? гэдгээ бодох • Эхээ хэдэн цогцолбортой бичих вэ? Агуулгын аль хэсэгт ямар ямар үйл явдал бичихээ жагсаах • Цогцолбор бүрийн утгыг агуулсан нэр өгөх • Өгсөн нэр, үйл явдлаа ашиглан бүдүүвч хийхдээ учир шалтгааны холбоо хамаарлыг яаж гаргахаа төлөвлөх • Бүдүүвч зургаа ашиглан эх зохион бичихдээ: <ul style="list-style-type: none"> ○ Дараалал заасан үг, учир шалтгааны холбоо хамаарлыг илэрхийлсэн холбох үг нөхцөл ашиглах ○ Гол санаандаа тохируулж үйл явдлаа төгсгөх ○ Найруулгын болон дүрмийн алдаагаа бичиж дууссаныхаа дараа дахин уншиж, сайжруулах • Тухайн бичвэрийг тогтсон загварын дагуу бичих 	<p>Н.Нарантуяа нар, Бичих чадварыг бүтээлчээр хөгжүүлэх нь, УБ., 2014</p>
<p>6.2б. Үлгэр, өгүүллэг зохиохдоо орон, цагийн дарааллаар өрнүүлэн, сэдэв, агуулгыг учир шалтгааны</p>	<ul style="list-style-type: none"> • Сэдэв сонгох • Гол санаагаа тодорхойлох • Агуулгын хэсэг бүрд дүрслэх үйл явдлаа сонгох • Зангилаа хэсгээ сонгох • Үйл явдлаа хэрхэн учир шалтгаан ба цагийн дарааллаар өрнүүлэхээ бодож, төлөвлөх • Ноороглох • Хянах 	<p>Н.Нарантуяа нар, Суралцагчдын бүтээлчээр унших, бичих чадварыг дэмжих арга зүй, УБ.,2014</p>

<p>уялдаа холбоотой бичих</p>	<ul style="list-style-type: none"> • Засах • Сийрүүлэх <p>Нэмэлтээр хийх үйл ажиллагаанууд</p> <ul style="list-style-type: none"> • Зураг хараад өгүүллэг зохиох • Харилцан яриа зохиох • Агуулгын аль нэг хэсгийг гүйцээх • Нэр гарчигт тохируулан таамаглаж бичих <p><i>Багшид зөвлөх нь</i> <i>Дээр хоёр зорилтыг хэрэгжүүлэхэд гол анхаарах зүйл нь уран зохиолын бус хүүрнэсэн эхийг бичихэд зайлшгүй хэрэгтэй бүтэц, загварыг зөв гаргаж бичихэд анхаарна.</i> <i>Харин уран зохиолын эх зохиоход үйл явдлын дарааллыг зөв гаргах, учир шалтгааны холбоо хамаарлыг сонирхолтой гаргаж, өрнүүлэхэд анхаарна.</i></p>	
<p>6.2в. Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг сонгож бичих</p>	<ul style="list-style-type: none"> • Сурагчид сэдвээ сонгож, сонгосон шалтгаанаа тайлбарлах • Сонгосон сэдвээр ямар гол санаа гаргахаа бодож олох • Сонгосон сэдэв, гол санаандаа тохирсон үйл явдлыг бодож, төлөвлөх • Үйл явдал өрнөх зангилаагаа яаж сонирхолтой хийхээ бодож төлөвлөх • Үйл явдалдаа тохирсон дүр сонгох • Дүрийнхээ онцлогт тохируулан орчин (цаг хугацаа, орон) сонгох • Гол санаандаа тохируулан, үйл явдлаа хэрхэн төгсгөхөө шийдэх <p>Дараах үйл ажиллагааны хувилбаруудаас сонгож хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Үйл явдлыг дэлгэрүүлэн бичих • Цуврал зургийг ажиглан хүүрнэмж эх зохион бичих • Хөгжим сонсоод хүүрнэмж эх зохион бичих • Түлхүүр үгийг ашиглан хүүрнэмж эх зохиох • Цөм өгүүлбэрийг дэлгэрүүлэх замаар хүүрнэмж зохиох • Материал цуглуулан эмхлэх, бүлэглэх замаар хүүрнэмж бичих • Өгөгдөл буюу асуултын дагуу хүүрнэмж эх зохион бичих <p><i>Багшид зөвлөх нь:</i> <i>Сэдэв гол санаанд тохируулан үйл явдлын зангилаа болон төгсгөлөө зөв хийхэд анхаараарай. Энэ үед сурагчдын бичсэн зохион бичлэгийг бусдын өмнө уншуулах, бусад нь сэдэв санаанд тохирсон үйл явдал сонгосон эсэхийг хянах, сайжруулах саналыг зөвлөх зэргээр хамтарч ажиллаарай. Ингэж ажиллахаар сурагчдын сэдэв, гол санааны талаарх ойлголт нь батажна.</i></p>	<p>Н.Нарантуяа нар, Суралцагчдын бүтээлчээр унших, бичих чадварыг дэмжих арга зүй, УБ.,2014</p> <p>Н.Нарантуяа нар, Бичих чадварыг бүтээлчээр хөгжүүлэх нь, УБ., 2014</p>
<p>6.2г. Эхэд өөрийн санаа, харилцан яриа оруулан</p>	<ul style="list-style-type: none"> • Уншсан, сонссон, харсан зүйлээсээ сэтгэл хөдөлгөсөн үг, өгүүлбэр, хэсэг, үйл явдлыг сонгож, сонгосон шалтгаанаа тайлбарлах 	

<p>дэлгэрүүлж бичих</p>	<ul style="list-style-type: none"> ○ Уншиж, үзэж, харж, сонсож байхад оюун ухаанд чинь ямар дүр зураг буув? ○ Тухайн үйл явдлын талаар өөрсдөд ямар санаа бодол төрөв? ○ Уншиж, сонсож, харж байхад санаанд чинь өөр ямар нэг үйл явдал тохиолдсон зүйл, болсон явдал, сонссон дуулсан юм санаанд чинь оров уу? ○ Чамд ямар сэтгэгдэл төрөв? /талархах, үзсэн ядах, жигших, зэвүүцэх, итгэмээргүй .. г.м / ○ Ямар мэдрэмж төрөв? / ... юм шиг, ...юмтай адилхан, ... юм болж байсан шиг гэх мэт / ○ Ямар дүгнэлтэд хүрэв? Юуг ухаарч ойлгож авав? гэх мэт асуултад хариулж бичих <ul style="list-style-type: none"> • Зохиол уншаад мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх • Зураг хараад сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Дуу, хөгжим сонсоод сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Хэн нэгний яриаг сонсоод сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Бодит хүмүүсийн амьдралын түүх замналыг уншаад сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Үзсэн харсан зүйлийнхээ талаар сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих • Хурал цуглаан уралдаан тэмцээнд оролцсон сэтгэгдэл, мэдрэмж, үнэлэлт дүгнэлт ... гэх мэт • Болсон үйл явдлаас төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх • Бодит байдлаас төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих <p>Харилцан яриа оруулах</p> <ul style="list-style-type: none"> • Үйл явдал хаана алгассаныг олох • Тэнд ямар асуудал болж байгааг тодорхойлох • Тэнд ямар дүрүүд ярилцаж болохоор байгааг тогтоох • Шууд ба шууд бус ярианы хэлбэрээс сонгон харилцан яриа зохиох • Эхэд оруулахдаа өмнөх хойтох хэсгийн үг, өгүүлбэрийн хэлбэржилт, холбоосыг засаж, тохируулах <p>Хэлц оруулахдаа</p> <ul style="list-style-type: none"> • Хэлц үгсийг тохирох газарт нөхөх • Үгийг хэлц үгээр солин найруулах • Хэлц үгийн ойролцоо эсрэг хэлцийг олж бичих 	<p>Н.Нарантуяа нар, Бичих чадварыг бүтээлчээр хөгжүүлэх нь, УБ., 2014</p>
<p>6.2д. Хэлц ашиглан мэдрэмж сэтгэгдлээ дүрслэн бичих</p>	<ul style="list-style-type: none"> • Эхээс мэдрэмж илэрхийлсэн, сэтгэгдэл илэрхийлсэн хэсгийг ялгах • Мэдрэмж илэрхийлсэн болохыг батлахын тулд ямар мэдрэхүйгээр дамжиж илэрснийг тодорхойлох • Сэтгэл хөдлөлийг ялгах • Сэтгэл хөдлөл, мэдрэмж, сэтгэгдэл 3 ямар ялгаатайг тодорхойлох • Ямар үгийн аймгийн үгээр илэрч байгааг тайлбарлах • Мэдрэмж, сэтгэгдэл, сэтгэл хөдлөлийг харуулсан хэлц үгийг цуглуулах • Хэлцийн утгыг тайлбарлах • Сэдэв сонгох 	<p>Анне Франкийн өдрийн тэмдэглэл</p> <p>Гүррагчаагийн өдрийн тэмдэглэл</p> <p>Алдартай хүмүүсийн</p>

	<ul style="list-style-type: none"> • Бичих төлөвлөгөө гаргах • Ноороглох • Ноороглохдоо хэлц ашиглан мэдрэмж сэтгэгдэл, сэтгэл хөдлөлөө бичих • Хянах • Сайжруулах 	<p>өдрийн тэмдэглэл</p> <p>Хэлц үгийн толь</p>
<p>6.2е. Товч мэдээллийг баримтаар дэлгэрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Эхийг уншаад гол мэдээллийг ялгах • Юуны тухай болохыг тодорхойлох • Түүнтэй холбоотой материал цуглуулах • Цуглуулсан материалаа ангилж, бүлэглэж, эмхлэх • Аль мэдээлэлтэй холбоотой болохыг тэмдэглэх • Мэдээллээ баримтаар дэлгэрүүлж бичих 	
<p>6.1ж. Үйл явдлыг хэн?, хаана?, юу?, яагаад?, хэрхэн?, яав? гэсэн асуултын дагуу мэдээлж бичих</p>	<ul style="list-style-type: none"> • Үйл явдлыг энгийн, ойлгомжтой, тодорхой бичиж сурахын тулд эхлээд хэзээ? хаана? яагаад? (ямар учраас, юунаас болж) хэн? юуг? яав? гэсэн асуултаар уншсан эхээс гол ба гол бус мэдээллийг ялгах • Эдгээр асуултын дагуу хурааж товчилж бичих • Тодорхой асуудал дэвшүүлэх • Асуудалд тохирсон үйл явдал бичих • Бичсэнээ дээрх асуултын дагуу шалгаж, хянах • Мэдээлж бичих явцдаа сэтгэгдэл, үзэл бодол оруулж бичих 	<p>Н.Нарантуяа нар, Бичих чадварыг бүтээлчээр хөгжүүлэх нь, УБ., 2014</p>
<p>6.2з. Өөрийн болон бусдын зохиосон эхийн найруулгыг судалж, үг илүүдсэн, давтсан зэрэг алдааг таньж, сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Найруулгын алдаатай зохион бичлэг юм уу найруулан бичлэгийг засан сайжруулна. Ингэхдээ: <ul style="list-style-type: none"> ○ Ойлгомжгүй үгийн доогуур зурах, тэмдэглэх ○ Сэтгэлийн өнгө аяс илтгэх хэлний нэгжүүдийн сонголт, утгыг ажиглах, тайлбарлах ○ Үг давтсан алдааг тодруулах, тэмдэглэх, засах ○ Хэлний нэгжүүдийг буруу хэрэглэснийг тодруулах, засах ○ Оновчгүй хэрэглэсэн үгийг тэмдэглэх, зөв байрлуулах, яаж сайжруулах талаар ярилцах • Ойролцоо утгат үгийн эгнээ үүсгэж, солин найруулах • Зарим үгийг хэлцээр солих • Зарим тохиолдолд уран дүрслэл бүтээж хэрэглэх • Толь бичиг ашиглах замаар сайжруулах <p><i>Багшид зөвлөх нь</i> <i>Утгыг тодорхой илэрхийлэх нь үгийн сонголттой шууд хамааралтай учир эхлээд үг сонголтын тухай ойлголтыг эхийн утгыг задлан шинжлэх явцдаа таниулна. Үүний дараа үг сонголтгоо засах, сайжруулах дадлага хийнэ. Ингэхдээ дээрх үйл ажиллагаануудыг хийнэ. Эхний үед багш найруулгын алдааг сурагчидтай хамтарч засан сайжруулах ба сурагчдад засах арга, техникийг ингэж ойлгуулна. Мөн энэ үед найруулгын алдааг засах тэмдэг тэмдэглэгээг таниулна. Засан сайжруулахад шаардлагатай үгийн санг судлахад толь бичиг хэрэг болох тул багш орчныг бүрдүүлсэн байх шаардлагатай.</i></p>	<p>Ж.Баянсан, Б.Чимгээ, Сурагчийн гарын авлага УБ, 2006</p>

<p>6.2и. Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих</p>	<ul style="list-style-type: none"> • Сонгож авсан үгсийг бүтцээр задлах, бүтцийн хэсэг тус бүрийг ялгаж таних • Тэдгээр бүтээврүүдийн нийлц дээр гарсан авианы өөрчлөлтийн шалтгаан, дүрмийг тайлбарлах • Алдаатай задалсан, бичсэн эхийг засаж бичих • Бүтээврүүдийг нийлүүлж бичих • Бүтээврүүдийг нөхөж бичих • Анаграмм тайлах • Цээж бичиг бичих • Дүрмийн бүртгэлийн дэвтэр хөтлөх <p>Багшид зөвлөх нь <i>Бүтээвэрээр задлан тайлбарлахдаа багш зөв бичих дүрэм тайлбарлахуйц үгсийг сонгож авсан байна. Мөн жинхэнэ нэр, үйл үгийн бүтцийн зааг дээрх зөв бичих дүрмийг багцлан таниулна.</i> <i>Ер нь бага ангид ихэнх дүрмийг судалсан байгаа. Тиймээс дүрмийг сэргээн сануулах дадлага ажлыг хийнэ. Гэхдээ 6-р ангид зөв бичих дүрэм нь бүтээврийн нийлц дэх зөв бичих дүрмийг тайлбарлах байдлаар гүнзгийрч орсон байгаа. Өөрөөр хэлбэл бага ангид дан зөв бичих дүрмийг дан судалж байсан бол 6-р ангид үгийн бүтэцтэй холбох замаар чадвар нь хосолмол болж байгаа.</i> <i>Бүтээврийн нийлц дэх зөв бичих дүрэм гэхээр ихэнх дүрмүүд хамаарч орж ирнэ.</i></p>	<p>Ж.Баянсан, Б.Чимгээ, Сурагчийн гарын авлага УБ, 2006</p> <p>Ө.Цэндсүрэн “Бодит чадвар” 7, УБ, 2007</p> <p>Ө.Цэндсүрэн “Бодит чадвар” 6, УБ, 2007</p>
---	--	---

СОНСОХ-ЯРИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>6.3а. Тодорхой сэдвээр ярилцахдаа гол асуудлыг ойлгон, асуулт асууж тодруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Өдөр тутмын амьдралаас сэдэвлэн (хичээл сургууль, гэр бүл, чөлөөт цаг ... гэх мэт) харилцан ярилцах • Бусдын ярихыг анхааралтай сонсох • Юуны тухай ярьж байгааг тэмдэглэх • Сонсох явцдаа чухал чухал гэж үзсэн санаануудаа тэмдэглэх • Тухайн сэдвийн хүрээнд ямар асуудлаар ярьж байгааг тэмдэглэх • Ойлгомжгүй юм уу? анхаарал татсан хэсгийг түлхүүр үг ашиглан тэмдэглэх • Илтгэгчээс тухайн сэдвийн хүрээнд дэвшүүлсэн асуудлын талаар өөрийнхөө тэмдэглэлийг ашиглан асуулт асуух • Болж буй үйл явдлын нөхцөл байдал (тааламжтай, хошигносон, дургүйцсэн, тааламжгүй)-ыг мэдэрч асуулт асуун яриаг өрнүүлэх <p>Багшид зөвлөх нь <i>Тодруулах асуулт асуух үед багш сурагчдын сонсоод ойлгох чадварыг давхар үнэлэх хэрэгтэй. Тодруулах асуулт асуухдаа заавал баримт, нотолгоон дээр тулгуурлахыг сануулаарай.</i> <i>Зарим сурагч сэдэвтэй огт хамааралгүй зүйл асууж, ярилцлага, хэлэлцүүлгийг өөр тийш нь эргүүлдэг. Тиймээс сурагчдыг зөвхөн сэдвийн хүрээнд яриа өрнүүлж сургахад анхаарна.</i></p>	

	<p><i>Харилцан яриа бол хоёроос дээш хүний хооронд болдог яриа юм. Зарим тохиолдолд сурагчид аль нэг нь зөвхөн асуугаад, нөгөө нь хариулах замаар өрнүүлээд байдаг. Тиймээс багш харилцан ярианы үед дээрх байдлыг анзаарч харах ба хэрэв аль нэг нь асуугаад, нөгөө нь хариулаад байгаа тохиолдолд яриаг зогсоож, дахин бэлтгүүлэх зэргээр ажиллаарай.</i></p>
<p>6.36. Санаа бодлоо бусдынхтай холбож харилцан ярих</p>	<ul style="list-style-type: none"> • Тодорхой сэдвээр асуудал дэвшүүлэх • Тухайн сэдвийн хүрээнд ярих асуудлуудаа жагсаах • Дэвшүүлсэн асуудлын хүрээнд материал цуглуулах • Цуглуулсан материалаа эмхэлж, цэгцлэх, бүлэглэх, ангилах • Тухайн сэдвийн хүрээнд ярих асуудлуудын талаар өөрийн үзэл бодол, баримт нотолгоон дээр тулгуурлан сэтгэгдлээ бичиж тэмдэглэх • Тухайн асуудлын хүрээнд ярилцах • Ярилцах явцад өөрийн үзэл бодол, сэтгэгдлээ илэрхийлэх • Санал нийлэхгүй тохиолдолд бусдын бодлыг хүндэтгэж, сайн тал нь юу байсныг үнэлж дүгнэх <p><i>Багшид зөвлөх нь:</i> <i>Ийм үйл ажиллагааны үед бүх хүүхдүүдийн бэлтгэсэн материал, ангилж бүлэглэсэн, өөрийн үзэл бодлоо илэрхийлж тэмдэглэсэн тэмдэглэлийг хянах хэрэгтэй. Түүний дараа бүх хүүхдийг ярианд оролцуулахад анхаарна. Бэлтгэлгүй ирсэн хүүхдүүд ярианд оролцдоггүй. Тэднийг анхааралтай сонсож, тодруулах асуулт асуух зэргээр хичээлд татан оролцуулна. Зарим хүүхэд хэт давамгайлж, үзэл бодлоо тулгах, бусдыг үгүйсгэх, яриаг дуустал сонсохгүйгээр яриаг нь тасалж, ярьдаг зэрэг сөрөг үзэгдлүүд гардаг учир багш хичээлийн эхэнд дүрэм гаргаж, түүнийгээ дагаж мөрдвөл зохино. Энд бусдын үзэл бодол, сэтгэгдэл, байр суурьтай өөрийнхийгөө холбон дүгнэлт гаргуулах, загвар бүдүүвчид оруулан тайлбарлах, шүүн дүгнэх, зөвлөх зэргээр идэвхтэй үйл ажиллагааг дэмжинэ.</i></p>

VII АНГИ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

Энэхүү баримт бичиг нь монгол хэл бичгийн шинэчилсэн хөтөлбөрийн дагуу долоодугаар ангид хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд нь багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой удирдамж болно.

УНШИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>7.1a. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал зэрэг хүн, юм, үзэгдлийн гадаад</p>	<p>Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжлэх</p> <ul style="list-style-type: none"> • Эхийн нэр, гарчиг, өмнөх үг зэргээс агуулгыг төсөөлөх • Танил бус үгийн утгыг толь бичгээс (хам сэдвээс) тодруулах • Эхийг цогцолбороор зааглах • Цогцолбороор заагласан үндэслэлээ тайлбарлах • Цогцолбор бүр эхэд ямар үүрэгтэй байгааг жишээгээр тайлбарлах • Эхийн А цогцолбортой Б цогцолбор агуулгын ямар уялдаа холбоотойг жишээгээр тодруулан тайлбарлах 	<p>Рубрук. Г “Монголын эзэнт гүрэнд зорчсон нь” УБ., 2000</p> <p>Золбаяр.Б “Бүгээн” УБ., 2012</p> <p>Карпини.П “Монголчуудын түүх”УБ., 2012</p>

<p>дотоод шинж, үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, тоочин дүрсэлсэн эхийн үндсэн шинжийг ялган таних</p>	<ul style="list-style-type: none"> • Б, В хэсгүүд нь эхийн эхлэлтэй болон хоорондоо ямар холбоотойг жишээгээр тайлбарлах • Эхийн төгсгөлийн хэсэг нь дээрх хэсгүүдтэй ямар уялдаа холбоотой байгааг жишээгээр тодруулан тайлбарлах • Гарчиг ба сэдвийн уялдаа холбоог тодорхойлох • Цогцолборуудын агуулгын ялгаа ба тэдгээрийн уялдаа холбоог загварчлан тайлбарлах <p>Тоочин дүрсэлсэн эхийн үндсэн шинжийг ялган таних</p> <ul style="list-style-type: none"> • Цогцолбор дахь өгүүлбэрүүдийн утгын дарааллыг ажиглах • Цогцолбор тус бүрд юуг тоочин дүрсэлснийг тодруулах • Цогцолбор дахь тоочилтоор зохиогч ямар санааг илэрхийлснийг тодорхойлох • Юм үзэгдлийн гадаад дотоод шинжийг нэг цагт зэрэгцүүлснийг жишээгээр тайлбарлах • Үйлийн хувирал өөрчлөлтийг нэг цагт зэрэгцүүлснийг жишээгээр тайлбарлах • Тоочин дүрсэлсэн эхийн үндсэн шинжийг ялган таних <p>Багшийн анхааралд:</p> <p>Эхийг бүтэц, цогцолбороор зааглахаас гадна цогцолбор тус бүр эхэд ямар үүрэгтэй байгааг, тэдгээрийн уялдаа холбоог тогтоож сургах нь өөрсдөө эх зохиохдоо эхийн хэсгүүдийг хооронд нь холбож, эх бол нэгэн бүхэллэг цогц гэдгийг ойлгоно.</p> <p>Эхийг бүхэлд нь унших явцад эхийн агуулгын бүтцийг баримжаалан уншиж ойлгохдоо:</p> <ul style="list-style-type: none"> • Эхлэл хэсэгт тайлбар, асуудал дэвшүүлсэн, дүгнэсэн гм-ээр юу байгааг • Гол хэсэгт хэрхэн өрнөж, тайлагдаж байгааг • Төгсгөл хэсэгт дүгнэсэн, асуудал дэвшүүлсэн гм тухайн хэсэг бүрд чухам юуг өгүүлснийг ойлгож унших юм. <p>Эхийг эхлэл, гол, төгсгөл хэсэгт эсвэл цогцолбороор задлах асуудал нь энд хамаарна. Хүүрнэн бичсэн бичил эхийн хувьд эхлэл, гол, төгсгөл хэсгээр ерөнхийд нь агуулгын бүтцийг багцлан хуваах нь тохиромжтой байдаг бол тайлбарласан эхийн хувьд цогцолбороор задлан тэдгээрийн хоорондын холбоо хамаарлыг нарийвчлан тайлбарлах нь чухал юм. Харин зэрэгцүүлэн тоочиж бичсэн эхийн хувьд бүтэц дараалал гэхээс илүү өгүүлбэрүүдийн логик дараалал, зэрэгцүүлэн авч үзэж буй юмс, тэдгээрээр дамжуулан илэрхийлж буй санаа чухал болно. Бүтцийн задлал хийснээр зохиогч цаашид санаагаа дэлгэрүүлэн элдэв аргаар эхийг холбон найруулсныг ажиглахаас гадна, цогцолборын доторх өгүүлбэрийн утга, улмаар үг, бүтээврийн утгыг ч нарийвчлан тайлбарлахад тустай болно. Түүнчлэн сурагчдын ойлгож унших чадварт нэмэр болох юм. Агуулгын уялдаа холбоог тогтоох суралцахуйн зорилтын хүрээнд сурагчдын аливаа юмсын дотоод зүй тогтол, холбоо хамаарлыг тогтоох чадвар хөгжих юм.</p>	<p>Мандир.Т “Хорин нэгэн зул” УБ., 2012</p>
	<p>Эхийн түлхүүр үг, өгүүлбэрээр сэдэв, гол санааг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> • Эхийг “.....” гэж нэрлэсний учрыг ярилцах • Танил бус үгийн утгыг толь бичгээс тодруулах • Эхийг цогцолбороор зааглах • Эхийг цогцолбороор заагласан үндэслэлээ тайлбарлах 	<p>Тоочиж дүрсэлсэн эх</p> <p>Нэргүй.Ж “Хүмүүсийн</p>

<p>7.1в. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал, товч танилцуулга, илтгэх хуудас зэрэг эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> • Цогцолбор тус бүрийн түлхүүр үг, өгүүлбэрийг тодруулах • Яагаад түлхүүр үг, өгүүлбэр гэж үзсэнээ батлан тайлбарлах • Цогцолбор бүрийн түлхүүр үг, өгүүлбэрийн утгын харьцаа хамаарлаас эхийн сэдэв, гол санааг тодорхойлох <p>Багшийн анхааралд: Түлхүүр үг: Эхэд олонтоо давтагдаж эхийн сэдвийг тодруулах үүрэгтэй үгс Түлхүүр өгүүлбэр: Цогцолбор бүрийн гол санааг илтгэх дүгнэлт өгүүлбэр Тухайн эхийн гол санааг ганц хоёр өгүүлбэрээр дүгнэн тайлбарлах нь хангалтгүй. Үүний тулд тухайн эхэд өгүүлэгдэж буй юм, сэдэв санаа, түүнд хандах зохиогчийн хандлагыг нэлээд дэлгэрэнгүй тайлбарлаж ярилцана. Эхэд зохиогч юуны тухай өгүүлэв? Хэлэх гэсэн санаагаа гаргахдаа гол өгүүлэгдэж байгаа юмаар юуг, яагаад сонгов? Ямар санааг дэвшүүлсэн юм бол? Яагаад энэ тухай ярих болов? Энэ асуудал яагаад чухал гэж? Бидэнд юу хэлэх гэсэн юм бол? гэх мэтээр эргэцүүлэн ярилцана. Эхийн гол санааг сурагчид гаргаж хэлбэл, “Чи яагаад тэгж бодож байна вэ? Эхээс хэд хэдэн баримт жишээг олж, баталж тайлбарлана уу” гэж ярилцах, эсвэл багш өөрөө эхийн гол санааг дэвшүүлж үүнийг эхийн гол санаа мөн, биш болохыг “Түлхүүр үг, өгүүлбэрээр баталж, эсвэл үгүйсгэж хэлнэ үү” гэх мэтээр сурагчдын бодох тунгаах чадварыг хөгжүүлэхэд анхаарна. Үүнээс гадна уншсанаа өөрийн амьдралын туршлага, тухайн сэдвийн талаар өөрт хуримтлагдсан мэдлэгтэйгээ холбох, итгэл үнэмшлээ болгох, түүнийг хэрэгцээтэй үедээ, янз бүрийн нөхцөл байдалд хэрэглэж сурах, өөрөөр хэлбэл, уншиж буй зүйлээ өөрийнхөө мэддэг, хийж чаддаг зүйлтэйгээ холбох, зохиогчийн илэрхийлсэн гол санааг өөрийнхөө бодол санаа, үйл ажиллагаатай харьцуулан бодож сургах нь чухал. Бид өнгөрсөн хугацаанд юу уншсан, юуг хэрхэн амьдралдаа хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэх явцад тохиолдсон саад бэрхшээл, ололт амжилтын тухай тэднээр тодорхой яриулж болно. Сурагчид эхийг уншаад, гол санааг ойлгохоос гадна тэдний дүгнэлт эхэд хэр үндэслэж байгааг, улмаар эхийн гол санааг амьдралтай холбон дүгнэлт гарган ярьж чадаж байгаа эсэхэд анхаарах хэрэгтэй. Эхийн гол санааг амьдралд тохиолдсон үйл явдалтай холбож тайлбарлахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> • Эхийн үйл явдал, утга санааны талаар тодорхой асуулт гаргаж ярилцах • Ямар сэтгэгдэл төрсөн бэ? Ийм үйл явдал бидний амьдралд тохиолддог уу? гэх мэт ярилцах • Уншсан эхийн үйл явдал, санааг өөрийн амьдарч буй цаг үетэйгээ харьцуулан дүгнэлт гаргах, хэлэлцүүлэг хийх • Сурагчдад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шүүмжлэлтэй хандах, төсөөлөн бодох чадвараа илэрхийлэх боломж олгох • Эхэд гарч буй үйл явдал, дүрд ёс суртахууны дүгнэлт хийх зэрэг уншигчийн байр сууринаас санал бодлоо илэрхийлэх 	<p>тухай роман” УБ.,2006</p> <p>Остров. Р “Хүчирхэг уншихуй” УБ.,2009</p> <p>Стееле. Ж.Л, Мереди.К.С, Темпл. Ч “Бүтээлчээр сэтгэгч” уншигчийг төлөвшүүлэх нь” ВСІ УБ., 2014</p>
---	--	---

	<ul style="list-style-type: none"> • Эхийн үйл явдал, санааг гүнзгийрүүлэн бодох, түүний амьдрал дахь хор холбогдол, түүнээс сэргийлэхийн тулд хэрхэх хэрэгтэйг дүгнэж ярилцах, мөн ач холбогдлыг нь ярилцах • Багш сурагчийн ярих, ойлгох чадварыг сайн хөгжүүлэхийн тулд сайн асуулт боловсруулж асуух 	
<p>7.1г. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал зэрэг эхээс содон сонин үг хэллэг, уран дүрслэл, хэлцийн утга, үүргийг тодруулж, тоочин дүрслэх арга хэрэглүүрийг ялган таних</p>	<p>Эхээс содон сонин үг хэллэгийн утга, үүргийг тодруулах</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс сонин содон үг хэллэгийг тодруулж унших • Яагаад сонин үг хэллэг болохыг жишээгээр тайлбарлах • Содон сонин үгсээр эхэд юуг дүрсэлж харуулсныг ярилцах • Содон сонин үг хэллэгийг эхэд хэрэглэсэн зорилгыг тодруулан тайлбарлах • Сонин содон үг хэллэгийн утгыг түүнийг үүрэгтэй холбон тайлбарлах • Содон сонин үг хэллэг дүрслэлд ямар үүрэгтэйг тодруулан ярилцах • Сонин содон үг хэллэг нь тоочин дүрслэх арга хэрэглүүр болохыг ялган таних • Содон сонин үг хэллэгийг зохиогч шинээр бүтээдэг, энэ нь монгол хэлний үгийн санг баяжуулдаг тухай жишээгээр ярилцах <p>Багшийн анхааралд: “Монгол хэл, бичгийн суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр” Уб. 2015 –д “содон сонин дүрслэл”, “зохиогчийн өвөрмөц үг хэллэг, дүр дүрслэл”, “адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал зэрэг уран дүрслэл” зэрэг ойлголтыг хөтөлбөрийн дахин сайжруулалт хийхэд дараах байдлаар цэгцэлснийг анхаарна уу. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Сонин содон дүрслэл”- ийг “Сонин содон үг хэллэг” гэж өөрчлөв. Үүнд зохиогчийн эхэд шинээр бүтээсэн үг хэллэгийг багтаан авч тайлбарлав. Цаашид ингэж тайлбарлана. • “Зохиогчийн өвөрмөц үг хэллэг, дүр дүрслэл”- гэсэн байсныг “хэлц” – гэж өөрчлөв. Үүнд монгол хэлний хэлц үгийн утга, үүргийг авч үзнэ. • “адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал зэрэг уран дүрслэл” – ийг “уран дүрслэл” гэдгээр нь авч тайлбарлана. Харин уран дүрслэлээс зөвхөн “адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал” байгааг багш анзаарах хэрэгтэй. <p>Эхээс уран дүрслэл (адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал)-ийн утга, үүргийг тодруулах</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс уран дүрслэлийг таних, ялгах • Уран дүрслэлээр дүрсэлж буй юмын юуг нь онцолж дүрсэлснийг тайлбарлах • “Харагдах, сонсогдох, хүрэлцэх, амтлах, үнэртэх” зэрэг мэдрэхүйн аль талаас дүрсэлснийг тайлбарлах • Уран дүрслэл хэрхэн бүтсэнийг тайлбарлах • Уран дүрслэл сонгосон зохиогчийн зорилгыг тодруулж ярилцах • Уран дүрслэлийн утгыг үүрэгтэй нь холбон тайлбарлах • Ямар уран дүрслэлээр юм үзэгдлийг нүдэнд харагдтал дүрсэлснийг жишээгээр тайлбарлах 	<p>Монсудар “Монгол хэлний өвөрмөц хэлцийн тайлбар толь” УБ., 2011</p> <p>Тоочиж дүрсэлсэн эх</p> <p>Стееле.Ж.Л, Мередит.К.С, Темпл.Ч “Хичээл бүрээр уншуулж, бичүүлж, яриулах” III дэвтэр. УБ., 2000.</p> <p>Стееле.Ж.Л, Мередит.К.С, Темпл.Ч “Бичих үйл явц сургалт семинар:</p> <p>Өөрийгөө илэрхийлэхээс үндэслэлтэй бичих хүртэл” VII дэвтэр. УБ., 2000</p> <p>Пүрэв-Очир. Б “Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим</p>

	<ul style="list-style-type: none"> • Уран дүрслэл нь тоочин дүрслэх арга хэрэглүүр болохыг ялган таних • Уран дүрслэл нь уншигчдад ямар сэтгэгдэл төрүүлж, яаж нөлөөлж байгааг тодруулж ярилцах • Зохиогч уран дүрслэлээс уншигчдыг юуг олж хараасай гэж хүссэнийг ярилцах • Юмсыг адил шинжээр нь зүйрлэж, адилтгаж уран дүрслэл бүтээдгийг, энэ харьцуулалт нь оновчтой бол уншигчийн урмыг сэргээж, сонирхол татаж, сэтгэл хөдөлгөхүйц дүрслэл болдог тухай жишээгээр ярилцах <p>Багшийн анхааралд: Уран дүрслэл нь эхийг сонирхолтой, амьтай, яруу сайхан болгодог учраас</p> <ul style="list-style-type: none"> • Уран дүрслэлийг эхээс олж, утга, үүргийг тодруулж ярилцах • Уншиж, уран дүрслэлийг задлан тайлбарласан эхээс сонгон, уран дүрслэлийг цээжлэх • Тогтоосон уран дүрслэлээ ярих, бичихдээ хэрэглэх • Уран дүрслэл бүтээх зэрэг алхмуудыг эзэмшихэд анхаарна. <p>Уран дүрслэл нь үндсэндээ хоёр юмыг аль ижил төстэй шинжээр нь адилтгах эсвэл нэг юмыг түүнтэй холбоо бүхий зүйлээр орлуулах гэсэн хоёр янз байна.</p> <p>Уран дүрслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Зэрэгцэх (адилтгал, зүйрлэл), (ихэсгэл, багасгал) • Орлох (төлөөлөл, тойруулал), (чимэглэл, егөөдөл) <p>Эндээс 7 дугаар ангид “Зэрэгцэх (адилтгал, зүйрлэл), (ихэсгэл, багасгал)” –ыг авч үзнэ гэдгийг анхаарна.</p> <p>Адилтгал: Нэг мм үзэгдлийн шинжийг өөр төстэй юм үзэгдэлтэй зэрэгцүүлэн тавьж дүрслэх (шиг, мэт, адил, шуу, втар, өөрцгүй, чинээ, магад) арга юм.</p> <p>Ихэсгэл: Юм үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодитой байж болох бололцооноос хэт ихэсгэн давуулж дүрслэх арга</p> <p>Багасгал: Юм үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодитой байж болох бололцооноос хэт багасган дүрслэх арга</p> <p>Эхээс хэлцийн утга, үүргийг тодруулах</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс хэлцийг ялгах • Хэлцийн утгыг хам сэдвээс тайлбарлах • Хэлц нь ямар уран дүрслэлээр бүтсэнийг тайлбарлах • Эхийн найруулгад хэлц ямар үүрэгтэй байгааг тодруулах • Хэлц нь дүрслэн бичихэд ямар үүрэгтэй байгааг эхийн жишээгээр ярилцах <p>Багшийн анхааралд: Хэлцийн утгыг тайлбарлуулаад өнгөрөх бус, хэлцийн найруулгад ямар үүрэгтэйг нарийвчлан ярилцана. Хэлцэд юмс үзэгдэл, байгаль дэлхий, хүн зоны амьдрал ахуй, ааш маягийг товойтол уран цэцэн дүрсэлсэн жишээ нэн элбэг.</p> <p>Хэлц нь эхэд:</p> <ul style="list-style-type: none"> • Ёгт, өргөн дэлгэр, гүн гүнзгий санааг илэрхийлнэ. • Хүний санаа сэтгэлийн мянга түмэн өнгө аясыг тусгана. 	<p>энерги, соёл хэрэглээ” УБ., 2009</p>
--	--	---

	<ul style="list-style-type: none"> • Хэлцийн дүрслэл, санаа нь ард түмний үндэсний ахуй сэтгэлгээтэй холбогдоно гэх мэт талаас жишээгээр тайлбарлаж ярилцана. <p>Хэлцээр нэгийг нөгөөтэй харьцуулан ажиглах чадвар, ажигласнаа дүрслэх чадвар илэрнэ. Юмсын адил шинжийг онож хэлсэнд хэлцийн дүрслэлийн үнэ цэн оршино. Хэлц нь монгол хүний ажигч гярхай чанарын илэрхийлэл гэдгийг жишээгээр батлан ярилцана.</p> <p>Эхээс тоочин дүрслэх арга хэрэглүүрийг ялган таних</p> <p>Эхийн гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлсэн арга хэрэглүүрийг тодруулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс гадаад, дотоод шинжийг тоочин дүрсэлсэн үг, өгүүлбэрийг таних, ялгах • Гадаад дотоод шинжийг тоочин дүрслэхэд ямар асуултад хариулагдах, ямар ямар үгийг голлон сонгосныг ярилцах • Гадаад дотоод шинжийг дүрсэлсэн үгийг утга, үүргээр нь бүлэглэх • Тухайн үгс гадаад, дотоод шинжийг дүрсэлснийг баталж тайлбарлах • Гадаад дотоод шинжийг дүрслэх ямар ямар арга хэрэглүүр байгааг тодруулах • Гадаад дотоод шинжийг дүрслэхэд тэмдэг нэр, сонин содон үг хэллэг, уран дүрслэл чухал үүрэгтэйг баталж ярилцах • Гадаад, дотоод шинжийг дүрсэлсэн арга хэрэглүүрийг хэд хэдэн эхээс харьцуулж тайлбарлах зохиогчдын хэрэглэсэн үг хэллэг ямар ялгаатайг харьцуулах <p>Үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлсэн арга хэрэглүүрийг тодруулан тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлсэн үгийг таних, ялгах • Үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрслэхэд ямар асуултад хариулагдах, ямар ямар үгийг голлон сонгосныг ярилцах • Үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлсэн үгийг утга, үүргээр нь бүлэглэх • Үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрслэхэд үйл үгийн найруулга, уран дүрслэл, дүрслэх ба дуурайх үг, тоочсон богино өгүүлбэрүүд чухал үүрэгтэйг тодруулан ярилцах • Үйлийн хувирал өөрчлөлтийг дүрслэх ямар ямар арга хэрэглүүр байгааг тодруулах • Үйлийн хувирал өөрчлөлтийг дүрсэлсэн арга хэрэглүүрийг хэд хэдэн эхээс харьцуулж тайлбарлах зохиогчдын хэрэглэсэн үг хэллэг ямар ялгаатайг харьцуулах <p>Үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрслэхэд үйл үг чухал үүрэгтэй болох нь:</p> <ul style="list-style-type: none"> • Үйл үгийн доогуур зурж тэмдэглэх • Үйл үгийг шууд ба шууд бус утгатай байгааг ярилцах • Шууд ба шууд бус утгатай үйл үгийн дүрслэлийн ялгааг харьцуулж, тайлбарлах 	
--	--	--

	<ul style="list-style-type: none"> • Үйл явдал, үйлдлээ тодорхой дүрслэхийн тулд оновчтой хэрэглэсэн дүрслэл, үг сонголтын жишээ эхээс сонгон тайлбарлах • Эхийн шууд ба шууд утгатай үйл үгийг солин найруулж, эхийн өнгө аяс, зохиогчийн үнэлэмжид ямар ялгаа гарч байгааг харьцуулах <p>Өгүүлбэрийн найруулга чухал үүрэгтэй болох нь:</p> <ul style="list-style-type: none"> • Тоочин дүрсэлсэн эхийн өгүүлбэрийн хэмжээг ажиглах • Эхийг ихэвчлэн богино өгүүлбэрээр найруулсныг тодруулан тайлбарлах • Өгүүлбэрүүд бүгд цагаар төгсгөхийн “-на” нөхцөлөөр гэх мэт ижил төгсгөлтэй байгааг ажиглах, энэ нь тоочилтод ямар нөлөөтэйг ярилцах <p>Тоочих найруулга чухал үүрэгтэй болох нь</p> <ul style="list-style-type: none"> • Тухайн эх нь яагаад “тоочиж дүрсэлсэн эх” болохын учрыг тодруулан ярилцах • “Тоочих” гэсэн үгийн утгыг тайлбарлах • “Дүрслэх” гэсэн үгийн утгыг тайлбарлах • Юм үзэгдэл, үйл явдлыг нэг цагт тоочин дүрсэлснийг тайлбарлах <p>Багшийн анхааралд: “... эхээс содон сонин үг хэллэг, уран дүрслэл, хэлцийн утга, үүргийг тодруулж, тоочин дүрслэх арга хэрэглүүрийг ялган таних” гэсэн суралцахуйн зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тэмдэг нэр, сонин содон дүрслэл, уран дүрслэл нь гадаад дотоод шинжийг тоочин дүрслэх гол арга хэрэглүүр болох талаас, • Уран дүрслэл, дуурайх ба дүрслэх үг нь үйлийн хувирал өөрчлөлтийг дүрслэх гол арга хэрэглүүр болох талаас, • Юм үзэгдэл, үйл явдлыг нэг цагт тоочин дүрсэлснийг аль аль эхэд задлан тайлбарлах замаар тоочин дүрслэх арга хэрэглүүрийг ялган таниулахад анхаарна. . 	
<p>7.1д. Эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах</p>	<p>Эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Эхийг анхааралтай унших • Эхээс тухайн бичлэгийн төрөл, онцлогийг гаргаж илэрхийлэхэд чухал нөлөөтэй хэсгийг тэмдэглэх • Яагаад чухал гэж үзсэн үндэслэлээ тайлбарлах <p>Багшийн анхааралд: Эхээс чухал хэсгийг олох гэхээр сурагч бүр өөр өөрийнхөөрөө чухал гэж үзсэнээ тайлбарлах тул үүнийг тодорхой болгоход багш анхаарна. Өөрөөр хэлбэл, юуг чухал гэж үзэх вэ? гэдэгт багш тухайн сэдвийн агуулга, зорилгоос хамааран тодруулж өгнө. Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Аян замын тэмдэглэл, хөрөг, танилцуулга, илтгэх хуудас зэрэг бичлэгийн төрлийн онцлогийг харуулахад чухал нөлөөтэй хэсгүүд • Тоочин дүрслэхэд чухал үүрэгтэй байгаа арга хэрэглүүрүүд • Хөргийн дотоод гадаад шинжийг дүрслэхэд чухал үүрэгтэй хэсгүүд • Эхийн гол санааг тодруулахад чухал үүрэгтэй байгаа хэсгүүд 	<p>Стееле.Ж.Л, Мередит.К.С, Темпл.Ч “Хичээл бүрээр уншуулж, бичүүлж, яриулах” III дэвтэр. УБ., 2000.</p>

	<ul style="list-style-type: none"> • Аян замын тэмдэглэл, хөрөг найрууллын зохиогчийн зорилгыг илтгэхэд чухал үүрэгтэй байгаа хэсгүүд гэх мэт 	
<p>7.1е. Эхэд тооны нэр, тэмдэг нэр, дүрслэх, дуурайх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэлзүйн шинж, найруулгын утга, үүргийг тодорхойлох</p>	<p>Эхэд тэмдэг нэрийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэлзүйн шинж, найруулгын утга, үүргийг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> • Эхээс тэмдэг нэрийг түүж бичих, тэмдэглэж унших • Эхээс тэмдэг нэрийг утгаар бүлэглэх • Эхээс тэмдэг нэрийн дүрслэлийн утгыг тайлбарлах • Өөр өөр эхэд хэрэглэсэн тэмдэг нэрийг харьцуулан тайлбарлах • Эхээс тэмдэг нэрийн бүтцийг задлан тайлбарлах • Эхэд тэмдэг нэр хэрэглэсэн учрыг тайлбарлах замаар утга, үүргийг тодорхойлох • Дангаар болон давхарлаж орсон тэмдэг нэр, шууд ба шууд бус утгатай тэмдэг нэрийн дүрслэлийн ялгааг ялгааг тайлбарлах • Тэмдэг нэр нь юмс үзэгдлийн шинжийг нүдэнд харагдтал дүрслэхэд онцгой үүрэгтэй байгааг жишээгээр тайлбарлах <p>Эхэд дуурайх ба дүрслэх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэлзүйн шинж, найруулгын утга, үүргийг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> • Үйл хөдлөлийн харагдах байдал буюу дүр байдлыг дүрсэлсэн үгийг тодруулах • Үйл хөдлөлийн сонсогдох байдал буюу дуу авиаг дүрсэлсэн үгийг тодруулах • Эхээс дуурайх ба дүрслэх үгийг утгаар бүлэглэх • Эхээс дуурайх ба дүрслэх үгийн бүтцийг задлан тайлбарлах • Эхэд дүрслэх ба дуурайх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, найруулгын утга, үүргийг тодорхойлох • Эхэд давтан хэрэглэсэн дуурайх, дүрслэх үгийн өгүүлэгчийн хандлага үнэлэмжийг тайлбарлах • Дуурайх, дүрслэх үгсийг ойролцоо утгат үгээр солин найруулах, утгын ялгааг ярилцах • Авианы найруулгын онцлогийг дүрс дуурайх үг, авиа дуурайх үгийн жишээн дээр тайлбарлаж, ийм үгсээр төрөл бүрийн утгын ялгааг гарган өгүүлбэр зохиох <p>Багшийн анхааралд: Хэлний зүй заах гэдэг бол зохиолчийн хэлний онцлогийг хүүхдээр судлуулах буюу зохиолчийн хэлний онцлог ялгааг хүүхдийн сэтгэлд буутал тайлбарлаж мэдрүүлэхийг хэлнэ. Үүний тулд “ЯАГААД” гэсэн асуултад хариулна. Жишээ нь: Зохиогч яагаад энэ эхэд “.....” гэсэн тэмдэг нэрийг сонгосон, яагаад “.....” гэсэн дүрслэх ба дуурайх үгийг сонгосон, эдгээр нь эхэд ямар утга, үүрэгтэй байна вэ? зэрэг асуултад хариулах нь хэл зүйг заах аргын гол баримжаа юм. Сурагчид тухайн үгсийг эхэд хэрэглэсэн учир шалтгааныг хэр тогтоож байна, тэр хэрээр хэрэглэх чадвар нь сайжирч, үгийн баялаг нь нэмэгдэж улмаар хэлний мэдрэмж нь хөгжинө. Тэмдэг нэр, дүрслэх, дуурайх үгээр юм үзэгдэл, үйл явдлыг нүдэнд харагдаж, сэтгэлд буутал дүрслэхээс гадна дүрсэлж буй зүйлдээ хандах зохиогчийн үнэлэмж хандлага илэрдгийг тайлбарлан ярилцана. Зохиогчийн зорилгоос шалтгаалан эхэд сонгосон бүтээвэр, үг, өгүүлбэрийн утга өөр өөр байгааг тодруулах бөгөөд эх дэх</p>	<p>А.Цог-Очир Монгол хэлний эхийн хэв маяг УБ.,2015</p> <p>“Хэл шинжлэлийн нэвтэрхий толь” Соёмбо УБ., 2012</p>

	<p>үгсийн өөр өөр хөг, өнгө аяс, утга үүргийг хэдийчинээ олон үгээр тайлбарлуулна, төдийчинээ л бичиж найруулахдаа үг онож сонгохыг эрмэлзэх тул утга, үүргийн задлан шинжлэлийг хам сэдвийн хүрээнд сайтар хийхэд анхаарна.</p>	
<p>7.1ж. Хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг эхийн жишээгээр тодруулан, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлах</p>	<p>Хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг эхийн жишээгээр тодруулах</p> <ul style="list-style-type: none"> • Өгүүлбэрүүдийг энгийн өгүүлбэр болгон задлах • Үйл явдлууд нэгэн цагт болж байна уу? Цуваа цагт болж байна уу? гэдгийг тодруулах • Энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбосон аргыг тодруулан тайлбарлах • Хэлэх аялга зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг тодруулан тайлбарлах • Зэрэгцүүлэн холбох үг зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг тодруулан тайлбарлах • Зэрэгцүүлэн холбох нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг тайлбарлах • Өгүүлбэрийн холбоосыг ажиглаж, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр хэрхэн бүтсэнийг тодорхойлох <p>Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> • Холбож найруулсан энгийн өгүүлбэрүүдийн байрыг сольж, цагийн утга өөрчлөгдөж байгаа эсэхэд дүгнэлт гаргах • Үйл явдлууд тус бүрнээ эзэнтэй байгааг ажиглуулах • Үйл явдлууд бие биеэ захирахгүй тэгш эрхтэй байгааг ажиглуулах • Эхэд юу юуг зэрэгцүүлэн дүрсэлсэн, үүгээр зохиогч ямар санаа илэрхийлж байгааг тайлбарлах • Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр нь хүн юм үзэгдлийн гадаад төрх байдал, дотоод мөн чанар, үйл хөдлөл, бодит байдлыг тодорхой нэгэн цагт зэрэгцүүлэн тоочиж дүрслэхэд, найруулгад тэгш хэм бүтээхэд чухал үүрэгтэйг тайлбарлах • Тоочих найруулгыг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрээр найруулсныг жишээгээр тайлбарлах <p>Багшийн анхааралд: Багш энэ суралцахуйн зорилтын хүрээнд энгийн өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбох арга хэрэглүүр, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, найруулгын үүргийг таниулахад чиглэсэн үйл ажиллагаа төлөвлөнө. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр нь хүн юм үзэгдлийн гадаад төрх байдал, дотоод мөн чанар, үйл хөдлөл, бодит байдлыг тодорхой нэгэн цагт зэрэгцүүлэн тоочиж дүрслэн бичихэд, найруулгад тэгш хэм бүтээхэд чухал үүрэгтэйг ойлгуулна. Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Намрын шөнийн одод гялалзаж, чийглэг сэрүүн агаар нуруу жиндүүлнэ. (нөхцөлдүүлэн холбох нөхцөлөөр холбогдсон зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр) • Хөвчид цас зузаан орсон боловч яг энүүхэн хавьдаа газар хар, хагд өвс халиурна.(С.Э) 	<p>Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал</p> <p>Базаррагчаа. М “Монгол хэлний өгүүлбэр судлал” УБ., 2015</p> <p>Базаррагчаа.М “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь” УБ., 2014</p>

	<p>(А, Б өгүүлбэр нь зэрэгцүүлэн холбох үг, Б, В өгүүлбэр нь аялга буюу тэг холбоосоор холбогдсон зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр)</p> <ul style="list-style-type: none"> Хөрөнгө баялгаас цатгалан сэтгэлгээ төрдөг. Цатгалан хүнээс ямагт бүдүүлэг авир гардаг. (тэг холбоосоор холбогдсон зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр) 	
<p>7.13. Эхэд эсрэг ба ойролцоо утгатай зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарлаж, найруулгын утга, үүргийг тодорхойлох</p>	<p>Эхэд эсрэг ба ойролцоо утгатай зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарлаж, найруулгын утга, үүргийг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> Эхэд эсрэг ба ойролцоо санаа хаана илэрч байгааг тодруулах Эсрэг ба ойролцоо утгатай үгийг түүж, эхэд сонгосон учрыг тайлбарлах Эсрэг ба ойролцоо утгатай үг нь ямар утга санаа, дүр байдал илтгэж байгааг тайлбарлах Эсрэг ба ойролцоо утгатай үгийн найруулгын үүргийг тодорхойлох <p>Багшийн анхааралд: Найруулгыг яруу сайхан болгоход ойролцоо үгийн нарийн ялгааг мэддэг байх явдал онцгой учир холбогдолтой юм. Үгс хэчнээн ойролцоо утгатай байлаа ч илтгэх утга, хэрэглэх цар хүрээгээрээ бие биеэсээ ялгарч байгааг тодруулан ярилцана.</p> <p>Ойролцоо үгийн найруулгын үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Бодол санааны ялгарааг тун нарийн оновчтой илтгэх Найруулгад нэг үгийг дахин давтаж, нуршуу болгохоос зайлсхийх Зэрэгцсэн ойролцоо үгийн тухайд нэгийн утга нөгөөгөө тэлж, санааны явцууг тэнийлгэж, утгыг илүү тод, олон талтай илэрхийлэх төдийгүй найруулгыг тэгш хэмтэй, сонсоход ая дантай, яруу сайхан болгох <p>Эсрэг үгийн найруулгын үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Юмсын эсрэг тэсрэг шинж чанар нь улам тод томруун болно. Уг юм үзэгдлийн зөрчилтэй, нарийн түвэгтэй шинж байдлыг илрүүлэх 	<p>Ө.Цэндсүрэн нар Монгол хэл 7 багшийн ном УБ.,2018 он</p> <p>Баттогтох. Д “Үгийн ширэнгээр бэдрэхүй” УБ., 2008</p>

БИЧИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
	<p>Сонин содон үг хэллэг, тэмдэг нэр, мэдрэмж сэтгэгдэл оруулан гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж хөрөг бичих</p> <ul style="list-style-type: none"> Хөрөгт ямар асуудлын тухай бичихээ сонгох Зан чанар, дотоод ертөнцийнх нь онцлогийг сайн мэдэх хүнийхээ дүрийг сонгох, судалгаа хийж, баримт мэдээлэл цуглуулах 	<p>А.Цог-Очир Монгол хэлний эхийн хэв маяг УБ.,2015</p>

<p>7.2a. Сонин содон үг хэллэг, тэмдэг нэр, мэдрэмж сэтгэгдэл оруулан, гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж хөрөг бичих</p>	<ul style="list-style-type: none"> Хөрөгт тухайн хүний юуг нь онцлон мэдээлэхээ төлөвлөх (Эрхэм сайхан чанарууд, хийж бүтээсэн зүйл, амжилт, авьяас чадвар, хүсэл мөрөөдөл нь юу вэ?, тэднийг хүмүүс юу гэж үнэлдэг... зэргийг уран сайхнаар дурдан танилцуулах) Хөрөг бичих бүтцээ төлөвлөх Төлөвлөгөөний дагуу бичих Бичсэнээ засаж сайжруулах Бичсэнээ дахин уншиж сайжруулах <p>Багшийн анхааралд: Сурагчдаар шууд хөрөг бичүүлэхээс өмнө хийлгэж болох үйл ажиллагааны хувилбарыг үзүүлэв. Гадаад дотоод шинжийг тоочин дүрслэхдээ урьдчилан бэлдсэн хөрөг зураг эсвэл бодит хүнийг ажиглуулах зэргээр бичүүлж болно.</p> <ul style="list-style-type: none"> Багш бэлдсэн 2 – 3 хөрөг зураг сурагчдад харуулж, хүснэгтэд дүрийн гадаад, дотоод шинжийг тодорхойлох үгсийг бичүүлнэ. (гадаад шинжийг хараад, харин дотоод шинжийг таамаглана.) <table border="1" data-bbox="412 821 1218 989"> <thead> <tr> <th>п</th> <th>Гадаад шинж</th> <th>Дүрслэл</th> <th>Дот</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td>Ааш зан</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td></td> <td>Давтагдашгүй чанар</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td></td> <td>Үзэл бодол</td> <td></td> </tr> <tr> <td></td> <td></td> <td>Яриа хөөрөө</td> <td></td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> Хөргийн эдгээр шинжийг ямар ямар тэмдэг нэрээр болон мөн юуг юутай, яаж адилтгаж, ихэсгэж, багасгаж урнаар дүрсэлж болох тухай хэсгээрээ ярилцаж хүснэгтэд үг, уран дүрслэл нөхөж бичих Багш өөрийн бүтээсэн уран дүрслэлээ сурагчдад танилцуулж, мөн хүснэгтэд нэмж бичих Сурагчид хөрөг бичихдээ хүснэгтэд бичсэн үгсийг ашиглах <p>Жишээ нь: Нэгдэх зураг гэж үзвэл: Гадаад байдал: Тавиад настай, ухаалаг, ажил хэрэгч, богино хар бор үс, үрчлээтэй дух, нимгэн уруултай, нүдний шилтэй Онцлог шинж: Өтгөн хөмсөг, ажил хэрэгч царайтай гэх мэт Дотоод шинж: Сууж зогсож байгаа байдлаас таамаглавал: өөртөө итгэлтэй, найдвартай, зарчимч Мэргэжил: Бизнесмэн Гэр бүл: Гэр бүлтэй, хүүхэдтэй Сонирхол: Шатар тоглодог...</p> <p>Жишээ нь: Хоёр дахь зураг гэж үзвэл: Гадаад байдал: Гучаад насны, хайнга хувцасласан, урт хар үстэй Онцлог шинж: Цулцгар хацар, өргөн хөмсөг, нөхөрсөг инээмсэглэл Дотоод шинж: Зургийн байдлаас таамаглавал: хөгжилтэй найрсаг, ажилдаа сонирхолтой, хүмүүстэй байх дуртай, хүн</p>	п	Гадаад шинж	Дүрслэл	Дот			Ааш зан				Давтагдашгүй чанар				Үзэл бодол				Яриа хөөрөө		<p>Ц.Сүхбаатар Монгол хэлний найруулга зүй</p> <p>Базаррагчаа.М нар “Монгол хэл” 10 (хөрөг бичих) УБ.,2012</p> <p>Батбаяр. Д “Бүтээхүйн зүй тогтол” УБ., 2007. Жикомпресс</p> <p>Баттогтох. Д “Үгийн ширэнгээр бэдрэхүй” УБ., 2008</p> <p>Нарантуяа.Н нар. “Суралцагчдын бүтээлчээр унших, бичих чадварыг дэмжих арга зүй” ВСI УБ.,2014</p> <p>Сүхбаатар.Ц “Монгол хэлний найруулга зүй” УБ., 2013</p>
п	Гадаад шинж	Дүрслэл	Дот																			
		Ааш зан																				
		Давтагдашгүй чанар																				
		Үзэл бодол																				
		Яриа хөөрөө																				

	<p>бүхэнтэй нөхөрсөг харилцдаг, дээр доор гэж ялгадаггүй, гэр бүл хүүхдэдээ маш их цаг зав гаргадаг. Мэргэжил: Сэтгүүлч Сонирхол: Загасчлах дуртай.</p> <p>Жишээ нь 3 дахь зураг гэж үзвэл: Гадаад төрх: Хөдөлгөөн удаан, тогтуун харц, зузаан уруул, булчинлаг бие, нүүрний хувирал ихтэй ярьдаг. Дотоод шинж: Хөгжилтэй, хайр татам, ухаалаг, олон найз нөхөдтэй, хошин шогийн мэдрэмжтэй, бусад хүний анхаарлыг татаж чаддаг, найз нөхөд нь түүнийг хүндэлдэг, ямар ч нөхцөл байдалд гэрэл гэгээтэй талыг хардаг, сайхан дуулдаг, ангидаа хамгийн шилдэг оюутан Сонирхол: Хөгжимд дуртай Дүгнэн бичих: Түүний талаарх чиний сэтгэгдэл, хандлага Дүрийнхээ гадаад дотоод шинжийг тоочиж бичээд, эндээс дүрээ хэн бэ? гэдгийг дүгнэж бичих Дүгнэлт: Тэр бол маш ухаантай, ажил хэрэгч хүн Дүгнэлт: Миний мэдэх хамгийн гайхалтай хүн... Төлөвлөлтөө гаргаад дээрх үг хэллэг, дүгнэлтээ ашиглаад дүрээ тоочин дүрсэлж бичнэ. Бичихдээ ямар тэмдэг нэр, сонин содон дүрслэл оруулж бичих вэ? гэдгээ сайтар төлөвлөх, найруулгаа хянах</p> <p>Сурагчид хөрөг найруулал бичнэ гэхээс илүү тоочин дүрсэлж бичих чадвар эзэмших гэсэн зорилгын үүднээс задалж, төлөвлөж, бичнэ. Хөрөг найруулал нь сонгож авсан баатрынхаа оюун санаа, дотоод ертөнцийг нээж, зан төрхийг зурагладаг. Баатрынхаа амьдралын замнал, давтагдашгүй онцлог, зан төрх, ололт амжилт, саад бэрхшээлийг даван туулсан туршлага, үзэл бодол, хүсэл сонирхол, гадаад байдал, хэл яриа зэрэг шинжид анхаарлаа төвлөрүүлж, бусдаас ялгарах онцлогийг гаргадаг. Энэ онцлогийн үүднээс бичүүлнэ гэвэл 7дугаар ангийн хүүхдэд хүндэднэ. 7дугаар ангид сурагчид аливаа юмсын гадаад дотоод шинжийг, ялангуяа гадаад шинжийг (7дугаар анги) зүй зохистой тоочиж дүрслэх, дүрслэхдээ сонин содон үг хэллэг, уран дүрслэл оновчтой сонгох чадвар эзэмшүүлэхэд л анхаарна. Сурагч найруулгад тэмдэг нэр, уран дүрслэл, сонин содон дүрслэлийг оновчтой сонгон хэрэглэж байгаа эсэхэд анхаарна. Аливаа үйл ажиллагаанд багшийн үлгэр маш чухал тул, багш урьдчилан сайтар бэлдэж, сурагчдад дүрсэлж ярьж, бичиж, яагаад энэ тэмдэг нэр, уран дүрслэл сонгосноо тайлбарлах, мөн тэдэнтэй хамтран хийх зэргээр хичээллэнэ.</p>	<p>Стееле.Ж.Л, Мередит.К.С, Темпл.Ч “Хичээл бүрээр уншуулж, бичүүлж, яриулах” III дэвтэр. УБ., 2000.</p>
	<p>Үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлж аян замын тэмдэглэл бичих Бичихийн өмнө: Санаагаа цэгцлэх</p>	<p>Базаррагчаа. М “Монгол хэлний сүегэр ба</p>

<p>7.26. Хэлц, уран дүрслэл, дүрслэх ба дуурайх үг ашиглан үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлж аян замын тэмдэглэл бичих</p>	<p>Цаас аваад очих дуртай, үргэлж очдог, тухайн газар нутгийн тухай уншсан сонссон, бусдад тайлбарлахыг хүссэн газруудыг цувуулан бичих</p> <ul style="list-style-type: none"> • Бичсэн газруудаас санаанд чинь хамгийн тод бууж байгаа нь аль нь байна вэ? • Алиных нь тухай хамгийн их боддог вэ? • Чухам алийг нь бусдад хамгийн сонирхолтой бичиж чадах вэ? <p>Тэр газрынхаа тухай бичихээр сэдэв сонгох</p> <ul style="list-style-type: none"> • Юуны өмнө уншигч сонсогчдод дүрсэлж буй газраа танилцуулах • Баримт мэдээлэл цуглуулах <p>Төлөвлөгөө хийх</p> <ul style="list-style-type: none"> • Аян замын тэмдэглэлд ямар ямар сонирхолтой, чухал зүйлийг оруулж, уншигчдын анхаарлыг татах вэ? • Аялсан газрынхаа байгалийн юу юуг, ямар үг хэллэг, дүрслэл ашиглан тоочин дүрслэх вэ? • Аялсан орон газарт тохиолдсон үйл явдлыг ямар дүрслэл, үг хэллэг ашиглан тоочин дүрслэх вэ? • Очсон газар нутгаа нүдэнд үзэгдэж, сэтгэлд буутал дүрслэхийн тулд тоочин дүрслэх ямар арга хэрэглүүрийг хэрэглэх вэ? • Ерөнхий зураглалаар эхлээд чухал зүйлсийг тодруулан харуулах (Жишээ нь: “Алтай” эхэд эхлээд Алтайн уулсын сүрлэг байдал, тэндээс Ховд голын хөндий, Цамбагарав уул...г.м) <p>Ноороглон бичих</p> <ul style="list-style-type: none"> • Бичиж эхлэхээсээ өмнө нүдээ аньж, эргэн тойрон дахь байгаль газар орныг дотроо дүрслэх, бодит зүйлийг хүрч мэдрэх, үнэрийг нь үнэртэх зэргээр төсөөлөх • Боловсруулсан төлөвлөгөөний дагуу эхний санаагаа ноороглон бичих <p>Бичиж эхлэх</p> <ul style="list-style-type: none"> • Газар орныг үгээр зураглан дүрслэхдээ уншигч энэ газарт байгаагүй гэдгийг мартаж болохгүй. <p>Нооргийг урьдчилан гаргасан төлөвлөгөөний дагуу бичнэ. Шаардлагатай бол сүүлд нь дахин зохион байгуулж, төлөвлөлтөө өөрчилж болно.</p> <p>Бичсэнээ засаж сайжруулах (Үйл хөдлөлийн дүр байдал, дуу авиаг нүдэнд үзэгдэж, сэтгэлд буухаар, уншигчдыг үйл явдлын дунд байгаа юм шиг мэдрэмж төрүүлэхээр бичлээ гэж бодолоо үг сонголт, найруулгаа хянах</p> <ul style="list-style-type: none"> • Уншигчдад танил бус тэр газрын тухай маш сайн сурталчилгаа болсон байхаар дүрслэх, аялсан газартай холбоотой сонирхолтой баримтат мэдээлэлтэй байх, оновчтой хэрэглэсэн үйл үг, тэмдэг нэр, уран дүрслэлээр тэмдэглэлээ улам өвөрмөц содон болгосон байх <p>Багшийн анхааралд:</p>	<p>найруулбарын тухай” УБ., 2003</p> <p>Батбаяр. Д “Бүтээхүйн зүй тогтол” УБ., 2007. Жикомпресс</p> <p>Баттогтох. Д “Үгийн ширэнгээр бэдрэхүй” УБ., 2008</p>
---	--	--

	<p>7 дугаар ангийн туршид хүүхдүүд дүрслэн бичсэн эх задалж, дүрслэн бичсэнээр тэдний ямар чадвар нь хөгжих вэ? гэдгийг багш мэдэж байх ёстой юм.</p> <ul style="list-style-type: none"> • Аливааг цоо шинээр, бусдаас өөрөөр харахын тулд ажигламтгай болно. • Үгийн сангаа баяжуулна. • Шинээр сэтгэх бүтээлч сэтгэхүй нь хөгжинө. • Үгийн мэдрэмжтэй болно. • Гоо зүйн мэдрэмжтэй болно. • “Шинэ санааны эрэл” – д мордоно. • Сайхныг олж харан, түүнээсээ сэтгэлийн таашаал хүртэх гээд хувь хүний сэтгэл доторх нарийн мэдрэмж болон насан туршид үлдэнэ. • Бүтээлчээр сэтгэх чадвар нь тухайн хүнд шинэ санааны шавхагдашгүй баялаг болж үлдэнэ. . 	
<p>7.2в. Тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашиглан танилцуулга, илтгэх хуудсыг тоочин бичих</p>	<p>Тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашиглан танилцуулга, илтгэх хуудсыг тоочин бичих</p> <ul style="list-style-type: none"> • Ямар асуудалд баримт бичгээ үйлдэх вэ? гэдгээ сонгосны үндсэн дээр бичих гэж буй зүйлийн гол агуулга юу болох, уг баримт бичгээр ямар ямар зорилгоор, ямар асуудлыг шийдэх гэж байгааг бодох • Бичих гэж буй зүйлээ эхлэл, өрнөл, төгсгөл гэх мэтээр бүтэцчилэн, хэсэг тус бүрд агуулгаа багцлах • Баримт бичгийн агуулгыг ерөнхийгөөс тусгай руу, чухлаас чухал бус руу чиглүүлж, систем дэс дараалалтай, уялдаа холбоотой, нэг нь нөгөөгөөс урган гарсан байдлаар бичих • Бичвэрийн агуулга, сэдэв өөрчлөгдөх буюу утга төгссөн тохиолдолд өгүүлбэрийг шинэ мөрөөс эхлэн бичих • Тухайн баримт бичигт байх ёстой бүрдлүүдийг стандартад заасны дагуу бүрэн, зөв үйлдэх • Баримт бичиг нь нэр төрлөөс хамааран харилцан адилгүй шаардлага тавигддаг тул түүнийг харгалзах • Албан ёсны, тогтсон үг хэллэг, нэр томъёог өргөн хэрэглэх • Эмх замбараагүй, утга авцалдаагүй мэдээллийг биш, үнэн зөв, ойлгомжтой, утга төгс, цогц, үндэслэлтэй мэдээллийг товч байдлаар бусдад хүргэх • Найруулга зүй сайтай, засвар оруулгагүй, үг үсгийн алдаагүй байх <p>Багшийн анхааралд: Албан бичгийн тусгай бүрдлийн стандарт, нөхцөл зааврыг нарийвчлан дагаж албан бичиг төлөвлөх, боловсруулах чадвар эзэмшүүлэхэд анхаарах</p> <p>Илтгэх хуудас: Үйл явдал, бодит байдлын үнэн зөвийг нотлох зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулсан баримт бичиг. Илтгэх хуудас нь зохиомжийн хувьд эхлэл (оршил, удиртгал), өрнөл (гол агуулга), төгсгөл гэсэн бүтэцтэй.</p>	<p>Танилцуулга, илтгэх хуудас</p> <p>Ц.Сүхбаатар Монгол хэлний найруулга зүй УБ.,2015</p> <p>Бигэрмаа.Д “Албан бичиг боловсруулах арга зүй, түүний найруулга” УБ.,2009</p>

	<p>Эхлэл буюу оршил хэсэгт:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль зүйн үндэслэл (ямар хууль тогтоомж, хэний шийдвэрийг үндэслэн) • Хийж гүйцэтгэсэн ажлын агуулга, зорилго • Бүрэлдэхүүн (ямар бүрэлдэхүүнтэй энэ ажлыг хийж гүйцэтгэсэн) • Хугацаа <p>Өрнөл хэсэгт: Хийж гүйцэтгэсэн ажил, авч хэрэгжүүлсэн арга хэмжээгээ тодорхой асуудал, сэдэв, ач холбогдлоор нь төрөлжүүлж, логик дараалалтай бичнэ.</p> <p>Төгсгөл хэсэгт: Хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, ач холбогдлыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгч, тухайн ажлыг сайжруулах, боловсронгуй болгох талаар, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа дэвшүүлнэ.</p> <p>Илтгэх хуудас бичихэд өөрсдийн өдөр тутмын ажил, үйл ажиллагааны талаар бичүүлэх, гол нь албан бичгийн найруулга гэдэг талаас бичүүлэхэд анхаарна.</p> <p>Албан бичгийн найруулга нь:</p> <ul style="list-style-type: none"> • Тогтсон загвараар бичих • Тоочих найруулгаар бичих • Үг шууд утгаар байх • Баримтад тулгуурлан бичих • Санаагаа товч тодорхой илэрхийлэх 	
<p>7.2г. Өөрийн болон бусдын зохиосон эхийн найруулгыг судалж, үг буруу хэлбэржүүлсэн, оновчгүй сонгосон зэрэг алдааг таньж, сайжруулах</p>	<p>Үг буруу хэлбэржүүлсэн, оновчгүй сонгосон зэрэг алдааг таньж, сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> • Эх, өгүүлбэрийн найруулгыг ажиглах • Эх өгүүлбэрээс үг буруу хэлбэржүүлсэн, оновчгүй сонгосон зэрэг алдааг таних • Найруулгын алдааг засаж сайжруулах • Найруулгын алдааг зассан үндэслэлээ тайлбарлах <p>Багшийн анхааралд: Үг буруу хэлбэржүүлсэн буюу хэл зүйн алдаа: Монгол хэлний үг бүтэх ёс, үгийн хэлбэржилт, хэл зүйн хэмжээг зөрчсөний улмаас үүсэх алдаа. Энэ алдаа нь өгүүлж байгаа зүйлийн утгад төдийлэн нөлөөлөхгүй, анзаарагдахгүй тохиолдол бий. Үг буруу сонгосон алдаа: Үгээ онож сонгоогүйгээс илэрхийлэх гэсэн зорилгодоо хүрч чадахгүй, тэр ч байтугай огт өөр ойлголт төрүүлж болох найруулгын алдаа. Энэ алдаа үүсэх шалтгаан:</p> <ul style="list-style-type: none"> • Тухайн ойлголтод тохирох үг сонгоогүйгээс • Ойролцоо утгатай үгийн хамгийн оновчтойг сонгоогүйгээс • Олон утгатай үгийг буруу сонгосноос • Уг юмыг онож нэрлээгүйгээс <p>Өөрийн болон бусдын найруулгын алдааг тогтмол засдаг, хянадаг байхад дадуулах. Эхний удаа ойр зуурын энгийн алдаагаа таньдаг, засдаг болох нь чухал. Зохиосон эхийн найруулгыг дахин дахин хянуулах, сайжруулах, хамгийн сүүлийн хувилбарыг эхнийхтэй харьцуулах зэргээр хичээллэх нь зохион найруулж сурахад чухал алхам болно. Өөрөөр хэлбэл, “Үгийг хэлж бичихдээ аль болох жигнэж, амталж, үнэрлэж, нягталж шалгаад, амт үнэр, өнгө, ирийг нь тохируулж</p>	<p>Ц.Сүхбаатар Монгол хэлний найруулга зүй УБ.,2015</p> <p>Стееле.Ж.Л, Меридит.К.С, Темпл.Ч “Бичих үйл явц сургалт семинар: Өөрийгөө илэрхийлэхээс үндэслэлтэй бичих хүртэл” ҮИИ дэвтэр. УБ., 2000</p>

	<p>хэрэглэж чадвал жинхэнэ утга төгс санаа, увдис шидэт хүчийг үзүүлэх болно” (Д.Баттогтох) гэсэн санааг найруулгад хэзээд анхаарах нь чухал юм.</p> <p>Бичихийн тулд: Санаагаа зөв илэрхийлсэн эсэх хийгээд санаагаа хаана яаж байрлуулах эсэх тухай огт бодолгүй ноороглох хэрэгтэй. Хоёрдахь удаагаа хуулан бичихдээ илүү зүйлийг хасаж, санаануудаа байх ёстой газрыг нь олж байрлуулах хэрэгтэй. Гуравдахь удаагаа хуулан бичихдээ сая санаагаа зөв илэрхийлсэн эсэх дээр ажиллах хэрэгтэй.</p>	
--	---	--

ЯРИХ-СОНСОХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>7.3а. Сургууль, анги хамт олны өмнө тулгамдсан асуудлаас сонгон, баримт мэдээллийг судалж, чухлыг сонгон, санаа бодлоо илэрхийлж ярих</p>	<p>Сургууль, анги хамт олны өмнө тулгамдсан асуудлаас сонгон, баримт мэдээллийг судалж, чухлыг сонгон, санаа бодлоо илэрхийлж ярих</p> <p>Юуг хэрхэн яаж ярихаа төсөөлөн бодох</p> <ul style="list-style-type: none"> • Хэнд ярих • Ямар зорилгоор ярих • Юун тухай ярих • Юуг онцлон ярих • Ямар сонирхолтой чухал баримт мэдээлэл цуглуулах • Яриагаа хэрхэн эхлэх • Яриагаа хэрхэн дуусгах <p>Ярих зүйлээ бичих</p> <ul style="list-style-type: none"> • Ярих зүйлийн сэдэв, санааг сайн ойлгох • Ярих зүйлийнхээ хүрээ, хэмжээг тогтоох • Ярих төлөвлөгөө гаргах • Санаагаа товч, оновчтой, хурц тод илэрхийлэх • Ярианы эхлэл, төгсгөлөө төлөвлөх • Хэрэгтэй эшлэлүүд авах • Бичсэнээ засаж найруулах <p>Урьдчилан ярьж бэлтгэх</p> <ul style="list-style-type: none"> • Дасгал, дасгал, дасгал. Аль болох олон удаа давтаж ярих дасгал хийх • Ярих хугацааг тодорхойлохын тулд бүх яриагаа ярьж үзэх • Өөрийгөө сонсох <ul style="list-style-type: none"> - Дууны өнгө, хөг аялга, зогсолт - Тайван тогтуун, утга төгөлдөр - Энгийн тод, ойлгомжтой байдал • Толины өмнө ярих дасгал хийж, дохио зангаа, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаа хянах <p>Бичих, ярих сэдвийг сонирхол, хэрэгцээндээ тулгуурлан сонгох</p> <ul style="list-style-type: none"> • Сургууль, анги хамт олны хүрээнд тулгамдсан асуудлын талаар ярилцаж, асуудлыг жагсаан бичиж, тэдгээрээс хэлэлцүүлэг хийх сэдвээ сонгох (компьютер, гар утас, гялгар уут, батерей гэх мэт ашиг тустай боловч зохисгүй хэрэглэвэл хор нөлөө учруулах зүйлсээс сонгон түүний зохистой хэрэглээний талаар бичих) 	<p>“Илтгэх урлаг ба шилдэг илтгэлүүд” Монгол лектор төв.”Бит пресс” УБ., 2010</p> <p>Ричардс.Ж, Рикет.Г “Мэтгэлцээн” УБ., 2001</p>

	<p>Багшийн санал болгосон эх сурвалжаас бичих, ярих сэдэвт холбогдох мэдээлэл, хэрэглэгдэхүүн цуглуулах, ангилж бүлэглэх</p> <ul style="list-style-type: none"> • Хэлэлцүүлэгт амжилттай оролцохын тулд өөрийн саналаа батлах тодорхой нотолгоо баримтыг өгүүлэл, ном, зохиол, илтгэл зэргийг бие дааж, үр дүнтэй унших, судлах • Сэдэвтэй холбоотой ном материал уншсан, судалсан, асуух асуултаа хүртэл чамбайлан бэлтгэсэн байх <p>Бичих, ярих зүйлээ төлөвлөх, арга хэлбэрийг сонгох</p> <ul style="list-style-type: none"> • Өөрийн санал бодлыг хэрхэн тодорхой илэрхийлэх, ямар асуух асуулт, дэмжих, батлах, үгүйсгэх баримт, жишээ зэргийг нэг бүрчлэн төлөвлөх, бэлтгэх <p>Ярих бэлтгэл хийх</p> <ul style="list-style-type: none"> • Яриагаа яаж эхлэх вэ? • Өөрсдийн санаа бодлоо бусдад хүлээн зөвшөөрүүлэхийн тулд цуглуулсан баримт нотолгоогоо яаж ашиглах вэ? • Эсрэг багийн саналыг ямар баримтаар няцаах вэ? гэх мэтээр бэлтгэх <p>Бусдын ярианд үнэлгээ өгөх, харьцуулах, санал, сэтгэгдлээ хэлэх</p> <p>Ярианы хичээл зохион байгуулахдаа сурагчдад ярих сэдвийг долоо хоногийн өмнө зарлах, сэдвээ дахин дахин бэлдэх тухай зөвлөх</p>	
<p>7.36. Тулгамдсан асуудлын хүрээнд хэлэлцүүлэг хийхдээ баталж нотолж, дэмжиж, үгүйсгэж ярих</p>	<p>Тулгамдсан асуудлын хүрээнд хэлэлцүүлэг хийхдээ баталж нотолж, дэмжиж, үгүйсгэж ярих</p> <ul style="list-style-type: none"> • Тулгамдаж байгаа асуудлыг жагсаах, эрэмбэлэх, сонгох • Тухайн асуудлыг аль талаас нь харж хэлэлцүүлэгт оролцохоо сонгох • Өөрийн хэлэх гэж байгаа санааг батлах баримт, мэдээлэл, нотолгоог цуглуулах • Эсрэг баг ямар мэдээлэл баримт нотолгоо ашиглаж болох талаар давхар судлан, няцаах үндэслэл цуглуулах • Бусдад нөлөөлж чадах хамгийн чухал баримт нотолгоонуудаа ялгаж бүлэглэх, цэгцлэх • Сэдвийн давуу талыг баримтаар баталж ярих • Сэдвийн давуу талыг баримтаар үгүйсгэж ярих • Саналыг дэмжиж санал бодлоо хэлэх • Баримтаар баталж ярих • Баримтаар үгүйсгэж ярих • Саналыг дэмжиж санал бодлоо хэлэх гэх мэтээр хэлэлцэх • Асуудлын талаар нэгдсэн саналд хүрэх <p>Багшийн анхаарах зүйл:</p> <ul style="list-style-type: none"> • Хэл ярианы зөв чанар: Утга зохиолын хэлний хэвшсэн хэм хэмжээнд дүйж байх • Хэл ярианы нарийн онч чанар: Яригч бичигч этгээдийн санаа бодолд дүйж байх • Хэл ярианы тов тодорхой чанар: Уншигч, сонсогч ухаарч ойлгоход хялбар байх 	<p>Ц.Сүхбаатар Монгол хэлний найруулга зүй УБ.,2015</p> <p>Ричардс.Ж, Рикет.Г “Мэтгэлцээн” УБ., 2001</p>

	<ul style="list-style-type: none"> • Хэл ярианы учир зүйн уялдаат чанар: Логикийн хуульд таарч байх • Хэл ярианы эгэл жирийн чанар: Чамирхсан, гоёж гоодсон биш байх • Хэл ярианы товч нягт чанар: Илүү дутуу үггүй, үгийг хэрэгцээгүйгээр давтахгүй байх • Хэл ярианы цэвэр ариун чанар: Этгээд, бүдүүлэг, гадаад үг хэрэглэхгүй байх • Хэл ярианы яруу дүрслэг чанар: Яруу сайхан дүрслэлтэй, сэтгэл хөдлөм ярих • Хэл ярианы сонсголон яруу чанар: Сонсоход яруу байх • Хэл ярианы баялаг чанар: Хэлний хэрэглэгдэхүүн нь аль болох олон төрөл байх 	
--	---	--

НАЙМДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

Энэхүү баримт бичиг нь монгол хэл бичгийн хөтөлбөрийн дагуу наймдугаар ангид хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд нь багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой удирдамж болно.

УНШИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>8.1а. Шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдвээр тоочин тайлбарласан, учир шалтгааныг тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, тайлбарласан эхийн үндсэн шинжийг ялган таних</p>	<ul style="list-style-type: none"> - Тоочин тайлбарласан эхийг унших - Эхийг баримт, үзэл бодол гэсэн хэсгээр ялгах - Тайлбарласан эх нь баримтад суурилан бүтдэгийг ойлгох - Эхийн эхлэл, гол, төгсгөлийг ялган тэмдэглэх - Ерөнхий ба дэд сэдвийг эхээс олох - Түлхүүр үгсээр баримжаалан эхийг цогцолбороор хэсэглэх - Цогцолборуудын байрыг сольж үзэх, агуулгын ялгааг ярилцах - Эхийн мэдээллийг түлхүүр үгсээр хураах - Эхийн хэсгүүдийг холбож буй холбоос үг, үг, өгүүлбэрүүдийг ялган тодорхойлох - Тайлбарламж эхэд түгээмэл хэрэглэдэг холбоос байгаа эсэхийг шинжлэх - Эхийн холбоос эхийн агуулгатай хэрхэн уялдаж байгааг тодорхойлох - Тоочин тайлбарласан, учир шалтгааныг тайлбарласан эхийн зохиогчийн зорилгын ялгаатай ба адил талыг тодорхойлж унших - Тоочин тайлбарласан эхэд уран дүрслэл, үнэлэлт дүгнэлт өгсөн хэсэг, шүүмж, эргэцүүлэл, баримт, тайлбар зэрэг байгаа эсэхийг олох - Эхэд юуг, хэрхэн тайлбарласан, тайлбарлахдаа юуг ашигласныг тодруулж унших - Дүрслэн тайлбарласан эхэд задлал хийж, онцлогийг нь ойлгохдоо, тайлбарлахдаа ямар арга ашигласныг тодруулж унших - Ямар ямар баримт ашигласныг тайлбарлах 	<ul style="list-style-type: none"> - Шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдвээр мэдээлж, дүрсэлж тайлбарласан, асуудал дэвшүүлсэн нийтлэлийн эхүүд,

	<ul style="list-style-type: none"> - Дүрслэл ашигласан хэсгийг тодорхойлох Тэр - Дүрслэхдээ яаж дүрсэлсэн, уран дүрслэлийн ямар арга хэрэглэснийг 	
<p>8.16. Учир шалтааныг тайлбарласан, дүрслэн тайлбарласан, тоочин тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох</p>	<p>Тоочин тайлбарласан, дүрслэн тайлбарласан, асуудал дэвшүүлсэн эхийн (шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдэвтэй) сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлохын тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Эхийг ерөнхийлөн баримжаалж унших - Эхийн түлхүүр үгсийг ялгаж, бүдүүвчээр тэмдэглэх - Эхийг бичсэн арга, эхийн хэлбэр хэмжээ, дэвшүүлсэн асуудал, зохиогчийн бичсэн зорилго, чухалчилсан санааг анзаарч тус бүрийг тодорхойлох - Эхийн сэдвийг илэрхийлсэн түлхүүр үгийг ялгаж тодорхойлох - Сэдвээс үүдэн зохиогчийн гол санааг тодорхойлох - Эхийг цогцолбороор задлах - Цогцолборуудын холбоосыг тодруулж унших - Дүрслэн тайлбарласан эхэд ашигласан хэлц, уран дүрслэлийг ялган, тайлбарлах - Хэлцийн уран дүрслэлийг тайлбарлах - Хэлцийн онцлогийг тодорхойлох - Зохиогч мэдрэмж сэтгэгдлээ хэрхэн илэрхийлснийг тодорхойлох - Эхийн түлхүүр үгийг тодорхойлох, тайлбарлах - Эхийн хэсгүүдийн уялдаа холбоог тодорхойлох - Баримт, дүрслэлийг ялган, тэдгээрийн үүргийг тайлбарлах <p>Багшид зөвлөх нь: Гол санаа ба сэдвийг ялган таних. Зарим сурах бичиг, гарын авлагад голлох үүрэгтэй түлхүүр үг хэллэг цогцолборын эхний, эсвэл төгсгөлийн өгүүлбэрт гарч ирдэг. Зарим ном зохиолд ийм үгсийг тодруулах, налуулах, өнгөөр будах зэргээр онцлон ялгасан байдаг. Түлхүүр үг нь цогцолборын сэдэв буюу юуны тухай өгүүлэх гэж буйг харуулдаг. Гэхдээ цогцолбор бүрийн гол санаа, агуулгыг тэр болгон илэрхийлдэггүй.</p> <ul style="list-style-type: none"> • Гол санааг өөрийн үгээр бичих. Гол санааг илэрхийлсэн өгүүлбэр хэтэрхий урт, нуршуу байвал хурааж, тийм өгүүлбэрийг зөвхөн утга санааг олгомжтой, цөөхөн үгээр солин бичиж болно. • Цогцолборуудыг уншиж гол санааг олох. Үүний тулд дараах асуултын дагуу унших <ul style="list-style-type: none"> ▪ Эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ? ▪ Цогцолбор бүрээр ямар утга санаа илэрхийлж байна вэ? 	<ul style="list-style-type: none"> - Н.Багабанди “Титэм үг” - Монгол хэлний хэвшмэл хэлцийн толь - Г.Аким “Өвөрмөц хэлцийн тайлбар толь” УБ., 1999 - Монсудар “Монгол хэлний өвөрмөц хэлцийн тайлбар толь” УБ., 2011 - Мэдээлэн тайлбарласан, дүрслэн тайлбарласан эх

	<ul style="list-style-type: none"> ▪ Цогцолбор бүрд тохирох нэр өгөх (цогцолборын санааг илтгэх үг, холбоо үгээр) ▪ Гол санаа нь аль цогцолборт илэрч байна вэ? Яагаад? <p>Эхийн гол санаа нэртэйгээ тохирч байна уу гэсэн асуултын дагуу ажиллаж гол санааг олж болно.</p>	
<p>8.1в. Уншсан эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган, учрыг тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> - Эхийн утгыг ойлгож унших - Зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялгаж унших - Нүдээр харж, чихээр сонсож, хамраар үнэрлэж, хэлээр амталж, биеэр хүртэж болохыг дүрслэн мэдрэмжээ илэрхийлсэн хэсгүүдийг тус бүрд ялган тодорхойлох - Мэдрэмжээ ямар үгээр илэрхийлснийг олж, ярилцах - Зохиогчийн мэдрэмжээс үүдэн төрсөн сэтгэгдлээ хуваалцах, ялгаатай сэтгэгдлүүдийг харьцуулах - Мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлсэн үгсийн утгыг тайлбарлах, хэлцийн утгыг тайлбарлах - Ном, бүтээлийг тайлбарлахдаа зохиогч ямар ямар уран дүрслэл ашиглан дүрслэн тайлбарласныг тодорхойлох 	<ul style="list-style-type: none"> - Н.Багабанди “Титэм үг” - Монгол хэлний хэвшмэл хэлцийн толь - О.Дашбалбар “Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгийн тухай”
<p>8.1г. Өргөдөл, хүсэлт, заавар зөвлөгөө зэрэг албан бичгийн эхийн бүтэц, үгийн санг задлан шинжилж, найруулгын онцлогийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Албан бичгийн эдгээр эхийн агуулга, бүтэц, хэл найруулгын онцлогийг тодорхойлох - Эхийн үгийн сангийн онцлогийг тайлбарлах - Эхийн агуулгыг харьцуулах - Эхийн эхлэл, гол, төгсгөлийн уялдааг тодорхойлох - Эхийн бүтцийг судалж унших - Хэл найруулгыг шинжлэх - Албан бичгийн эхийн тогтсон загваруудыг тодорхойлох - Хэд хэдэн төрлийн өргөдлийн бүтэц, агуулга, хэл найруулгыг судалж унших - Харьцуулж унших - Өргөдлийн бүтцийг ажиглаж, дүгнэлт гаргах - Өргөдлийн хэсэг бүрийн онцлогийг ярилцах - Өргөдөлд хэрэглэсэн үг хэллэгийг ажиглаж, дүгнэлт гаргах <p>Багшид зөвлөх нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Мөн бүтэц, агуулгын хувьд шаардлага хангасан болон хангаагүй өргөдөл сонгон уншуулж, сайжруулан найруулах дадлага хийлгэж болно. 2. Өргөдөл бичих дадлага хийнэ. Үүний тулд сурагчдад дараах боломж олгоно. <ul style="list-style-type: none"> • Юу хүсэж байгаагаа эргэцүүлэх • Хэнд хандаж бичихээ бодох • Хүсэж байгаа зүйлийн учир шалтгааныг бодох • Санаагаа хэрхэн буулгахаа бодох шийдэ, төлөвлөх • Санаагаа буулган бичих • Бичсэнээ уншиж, хянах 	<ul style="list-style-type: none"> - Өргөдөл - Хүсэлт, - Заавар - Зөвлөгөө зэрэг албан бичгийн эх

<p>8.1д. Эхээс баримт мэдээллийг ялгаж, бүтэц дараалалтай холбон, дүгнэх</p>	<p>Тоочин тайлбарласан эхийн баримт мэдээллийг ялгаж, эхийн бүтэц дараалалтай холбож тайлбарлахын тулд</p> <ul style="list-style-type: none"> - Тоочин тайлбарласан эхийн утга, бүтцийг тодорхойлох - Цогцолборуудын дарааллыг анхаарч унших - Эхийн эхлэл, гол, төгсгөлийг ялгаж унших - Эхийн бүтэц, утгын холбоо хамаарлыг бүдүүвчээр харуулах - Эхийн сэдэв, дэд сэдэв, дүгнэлт хэсгийн уялдаа холбоог тодорхойлох - Зохиогчийн зорилгыг тодорхойлох - Тоочин тайлбарлаж бичих онцлогийг илрүүлэх - Үгийн утгыг шинжлэх - Өгүүлбэр, цогцолборуудын холбоос дарааллыг тодорхойлох - Эхийн баримтад шинжилгээ хийх <p>Багшид зөвлөх нь: Тоочин тайлбарласан эх нь өгүүлэгчээс мэдээлэл дамжуулах зорилгоор, голдуу хэн?, хэзээ?, хаана?, юуг?, яав? гэсэн асуултад хариулж бичсэн товч мэдээлэл байдаг. Бичих аргын хувьд тодорхойлон тоочих, зохиогчийн зорилгын хувьд танин мэдүүлэх, мэдээлэх зорилгыг агуулдаг. Тиймээс голдуу баримтад тулгуурлан бичнэ. Сурагчид ийм төрлийн эхээс баримт гэж үзэж байгаа үг хэллэгийг багшийн чиглүүлсэн асуултаар ялгаж олно. Жишээбэл:</p> <p>Амарбаясгалант хийдийг Монголын анхдугаар Богд гэгээн Занабазарын дурсгалд зориулан Монгол нутагт байгуулах зарлигийг Энх-Амгалан хаан 1722 онд буулгажээ. Арван түмэн лан мөнгө улсын сангаас гаргаж, 1726 оны улаан морин жил бариулж эхлээд 1737 оны улаан луу жил бүрэн дуусгасан энэ хийд 300-аад жилийн түүхтэй Монголын эртний түүх, соёл, шашны үнэт өв юм. Түүнийг 1990 оноос сэргээн босгожээ.</p> <p>– Эхэд ямар ямар баримт байна вэ? - Баримт мөн гэдгийг юугаар батлах вэ?</p> <ul style="list-style-type: none"> • <i>Баримтыг үнэлж цэгнэх.</i> <p>Зураг харуулж, түүний тайлбартай харьцуулах замаар тайлбарын үнэн худлыг шалгаж болно. Жишээ нь: Гурван хүний хоёр нь гитар тоглож, нэг нь аман хуур тоглож байгаа зургийг тайлбарлахдаа “1. Гурван хүн хөгжим тоглож байна. 2. Хоёр нь аман хуур, нэг нь морин хуур тоглож байна.” гэжээ. Энэ тайлбарт байгаа баримтын эхнийх нь үнэн, харин хоёр дахь нь худлаа мэдээлэл байна. Иймээс аливаа баримт нотолгоо үнэн үү, үгүй юу гэдгийг заавал яг ингэж өөрийн биеэр юм уу өөр мэдээллийн эх булаг ашиглан шалгаж байх хэрэгтэй.</p>	<ul style="list-style-type: none"> • Шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдвээр мэдээлж, дүрсэлж тайлбарласан, асуудал дэвшүүлсэн нийтлэлийн эхүүд, • “Монгол гэр” “Гурван Цэнхэрийн агуй” танин мэдэхүй, мэдээллийн эх
---	---	--

	<ul style="list-style-type: none"> • <i>Баримт, дүгнэлт, сэтгэгдлийн үнэн мөнийг тогтоох</i> <p>Та аливаа нэг баталгаа, дүгнэлт, сэтгэгдэл уншвал заавал тэдний найдвартай, үнэн зөв эсэхийг тогтоох ёстой. Энэ бүгд үнэн гэдэгт итгэж болох уу? Эдгээр баталгаанд итгэж болох эсэхийг та яаж шийдэх вэ?</p> <ul style="list-style-type: none"> • <i>Зохиогчийн дүгнэлт, үзэл бодол илэрхийлсэн хэсгийг олох</i> 	
<p>8.1е. Уншсан эхэд дэвшүүлсэн асуудлын шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлж, загварчлах</p>	<ul style="list-style-type: none"> - Шалтгаан ба үр дагаврын ялгааг тодорхойлох - Эхийн дэвшүүлсэн асуудал, түүний шалтгааныг илрүүлэхийн тулд хэлэлцүүлэг хийх - Нийгэмд тулгамдаж буй асуудлын талаар ярилцах, тэдгээрийн шалтгааныг үндэслэлтэйгээр гаргаж ирэхийн тулд баримт мэдээлэлд суурилан дүгнэх - Эхийн агуулгыг шинжлэх - Эхийн цогцолбор бүрийн утга санааг тодорхойлж унших - Гол санааг дүгнэж, ярилцах - Шалтгаан үрийн холбоог бүдүүвчээр илэрхийлэх - Янз бүрийн асуудлын уялдаа холбоог тодорхойлох, баримтуудыг харьцуулах - Мэдээллийг жишээгээр батлах - Эхийг хураах, хувиргах - Эхийн хэсгүүдийг уялдааг тодорхойлох - Жишээ баримтад ажиглалт хийх - Шалтгаан үрийг харьцуулан ажиглах 	<ul style="list-style-type: none"> • Шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдвээр мэдээлж, дүрсэлж тайлбарласан, асуудал дэвшүүлсэн нийтлэлийн эхүүд,
<p>8.1ж. Уншсан эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж, дүгнэлт гаргах</p>	<ul style="list-style-type: none"> - Эхийг харьцуулан унших - Эхэд баримтыг төрөл бүрийн хэлбэрээр бичдэгийг ойлгож унших - Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх - Хүснэгтэн мэдээллийн графикаар илэрхийлэх - Хүснэгт, тоон мэдээллийг өгүүлбэрээр илэрхийлэх - Мэдрэмж сэтгэгдлээс баримт мэдээлэл ялгаатай болохыг ойлгож унших - Баримт тайлбарыг уран сайхны аргаар бичихдээ ямар арга ашигласныг тодорхойлох - Баримт мэдээллийг, уран дүрслэлтэй харьцуулан дүгнэх 	<ul style="list-style-type: none"> - Шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдвээр мэдээлж, дүрсэлж тайлбарласан, асуудал дэвшүүлсэн нийтлэлийн эхүүд,

<p>8.1з. Шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтсэн аргыг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Хоёр ба түүнээс дээш нийлмэл өгүүлбэрийг утгаар задлан тайлбарлах - Шалтгааны утгат холбоос хэрэглүүрийн үүргийг тодорхойлох - Угсарсан нийлмэл үг ба өгүүлбэрийг харьцуулан адил ба ялгаатай шинжийг тодруулах - Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгож задлах - Учраас, тул, тулд, учир, улмаас, бол, - тал⁴, - бал⁴, вал⁴, - нгуут², - нгаа⁴, - аад⁴ гэх мэт холбоосуудын утга үүргийг тодорхойлох - Уран сайхны найруулга бүхий өгүүлбэрийн жишээг задлан тайлбарлах 	<ul style="list-style-type: none"> - Шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдвээр мэдээлж, дүрсэлж тайлбарласан, асуудал дэвшүүлсэн нийтлэлийн эхүүд - Шалтгааны утгат угсарсан нийлмэл өгүүлбэр
<p>8.1и. Нутгийн аялгууны үг, гадаад үг хэллэгийн найруулгын үүргийг тодорхойлох</p>	<p>Нутгийн аялгууны үг, гадаад үг хэллэгийн найруулгын үүргийг эхийн үгийн санг ажиглах замаар тодорхойлох, зөв хэрэглэхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Ялгаатай ойлголтуудыг тодруулах - Ижил талыг тодорхойлох - Хэл ба аялгууны харьцааг тодорхойлох - Таамаглал дэвшүүлэх - Нутгийн аялгууны үгийг хэрэглэх - Хэл соёлын шүтэлцээг тодорхойлох - Эхээс гадаад үгсийг тэмдэглэх - Тэдгээр үгс ямар утгатай болохыг тайлбарлах - Тэдгээр гадаад үгсийг монгол хэл рүү хөрвүүлбэл юу гэж нэрлэж болох талаар өөрсдийн саналаа дэвшүүлэх - Тухайн үгс нь эхэд ямар үүрэг гүйцэтгэж байгааг тайлбарлах - Олон улсад тогтсон нэр томъёо нэршлийг гадаад үгээр тэмдэглэдэг гэдгийг ойлгох - Гадаад үгийг хэт их ашиглах нь эх хэлэнд сөргөөр нөлөөлөх эсэх талаар ярилцах 	<ul style="list-style-type: none"> - Буриад, өөлд, ордос, урианхай, торгууд зэрэг нутгийн аялгууны үгс - Нутгийн аялгууны үгийн толь
<p>8.1к. Угсарсан нийлмэл үгийг ялган таньж, эх өгүүлбэрт гүйцэтгэсэн найруулгын үүргийг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Эх ба өгүүлбэрээс нийлмэл үгсийг ялган, тэдгээрийн бүтсэн арга, хоорондын угсрах ба зэрэгцэх харьцааг ажиглах, асуулт тавих, өгүүлбэрт ямар утга, үүрэгтэйг нь тодорхойлох, хэлэлцэх - Уншсан эхээс нийлмэл үгийг асуултын тусламжтайгаар олох - Нийлмэл үгсийн бүрэлдэхүүнд байгаа үгсийн үүргийг ажиглах, бүлэглэх - Нэг нь нөгөөгөө захирсан (УНУ) үгсийн бүтсэн аргыг ажиглах, тайлбарлах - УН үгийг тодорхойлох - Нийлмэл үгийн бүтсэн арга, тэдгээрийн хоорондын харьцааг ажиглах, замаар өгүүлбэрт ямар утга, үүрэгтэйг тодорхойлох - Үгсийн утгыг тайлбарлах, тайлбар толь хөтлөх - Шууд ба шууд бус утгаар ялгах 	<ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн зүйлчилсэн утгаар бүлэглэсэн угсарсан нийлмэл үгийн жишээ

БИЧИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>8.2а. Жишээ баримтаар баталж, уялдаа холбоотой тоочин тайлбарлаж бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Сэдвээ тодорхойлох - Сэдэв сонгох - Мэдээлэл цуглуулж бүлэглэх - Мэдээллээ эмхлэх, цэгцлэх - Бичих төлөвлөгөө гаргах - Төлөвлөхдөө бүдүүвч, хүснэгт зэргийг ашиглах - Ноороглох - Хамтран бүтээл хийх - Өөрийн зохиосон эхэд өгсөн бусдын саналыг тэмдэглэх, тусган сайжруулах - Бусдын зохиосон эхээс тодруулан асууж, сайжруулах санал хэлэх, зөвлөх, хэлэлцэх, ойлголцох, хамтарч ажиллах чадвараа хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Агаарын бохирдол ба эрүүл мэндийн сэдэвт эх - Шинжлэх ухаан, танин мэдэхүйн эх
<p>8.2б. Хэлц, уран дүрслэл ашиглан үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ тусган найруулж бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Хэлцийн гол санааг дэлгэрүүлж дүрслэн тайлбарлах - Хэлцийг дэлгэрүүлэн эх зохиох төлөвлөгөө гаргах - Хэлцийг утгаар бүлэглэх - Хэлц ба уран дүрслэлийг эхийн аль хэсэгт ашиглахаа төлөвлөх - Хэлцийн утгыг тайлбарлахдаа ямар баримт ашигласныг тодорхойлох - Хэлцийн тайлбарыг дэлгэрүүлэн бичих - Хэлцийг ашиглахдаа юунаас үүдсэнийг эрж сурвалжлах, мэдээлэл цуглуулах - Ойролцоо ба эсрэг утгат хэлцийг ашиглах - Зургаас төрсөн сэтгэгдэл бичихдээ уран дүрслэл ашиглах - Номоос төрсөн сэтгэгдэл бичихдээ уран дүрслэл ашиглах - Дүгнэлт болон төрсөн сэтгэгдлээ илэрхийлэхдээ зохиолоос баримт мэдээлэл эш татаж, түүнд үндэслэн хэрхэн дүгнэж байгаа илэрхийлэх <p>Багшид зөвлөх нь: Зохиол бүтээлийн тухай шинэ санаа гаргаж, дүрслэл ашиглан мэдрэмж сэтгэгдэл, үнэлэлт дүгнэлтээ илэрхийлэхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Зохиолыг анх уншихад ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байсан бэ? 	<ul style="list-style-type: none"> - Г.Аким “Хэлц үгийн тайлбар толь” - Ц.Шагдарсүрэн “Монголчуудын утга соёлын товчоо” - Д.Баттогтох “Үлгэрээс үүдсэн хэлцийн толь” - Уран зураг

	<ul style="list-style-type: none"> - Зохиолоос хамгийн анхаарал татсан сонин содон үг хэллэг, сонирхолтой хэсэг юу байсан бэ? - Зохиогч энэ зохиолоороо дэвшүүлсэн гол асуудал юу вэ? - Энэхүү дэвшүүлсэн асуудлын хүрээнд гаргасан зохиогчийн үзэл бодол хандлагатай чи хэр зэрэг санал нийлж байна вэ? - Зохиолыг хэрхэн дүгнэж байна вэ? Энэ зохиолыг хамгийн тохиромжтой нэг үгээр тодорхойл гэвэл юу гэж хэлэх вэ? гэх мэт асуултаар чиглүүлж сурагчдын үзэл бодлыг сонсоно. 	
<p>8.2в. Өргөдөл, зөвлөгөөг албан бичгийн тогтсон бүтэц, загварын дагуу учир шалтгаан, холбоо хамаарлыг гаргаж бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Эхийн бүтэц, бичлэг, хэлний онцлогийг танин мэдэх - Хэд хэдэн төрлийн эх уншиж, ажиглах - Эхийн бүтцийг ажиглаж, дүгнэлт гаргах - Эхэд хэрэглэсэн үг хэллэгийг ажиглаж, дүгнэлт гаргах - Бүтэц, агуулгын хувьд ялгаатай эхийг сонгон уншиж, сайжруулан найруулах дадлага хийх. - Бичих дадлага хийхийн тулд сурагчид дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. <ul style="list-style-type: none"> • Юу хүсэж байгаагаа эргэцүүлэх • Хэнд хандаж бичихээ бодох • Хүсэж байгаа зүйлийн учир шалтгааныг бодох • Санаагаа хэрхэн буулгахаа бодох шийдэ, төлөвлөх • Санаагаа буулган бичих • Бичсэнээ уншиж, хянах 	<ul style="list-style-type: none"> • Өргөдөл • Заавар • Зөвлөгөө зэрэг албан бичгийн эх
<p>8.2г. Угсруулан холбох үг, нөхцөлүүдийг ашиглан учир шалтгааныг тайлбарласан эх зохиож бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэрээр задлах - Хоёр өгүүлбэрийн байрыг сольж найруулан бичих - Өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон задлах, байрыг нь сольж бичихэд ямар өөрчлөлт гарч байгаа талаар ярилцах, дүгнэлт гаргах - Энгийн өгүүлбэрүүдийг учир шалтгааны холбоос ашиглан нийлмэл өгүүлбэр болгох - Эх өгүүлбэр хувирган бичихдээ өгүүлбэрийг зөв холбож найруулах - Өөрийн болон бусдын зохиосон өгүүлбэрийн найруулгыг засаж сайжруулах - Хэд хэдэн цогцолборыг нийлүүлэн эхийг найруулан бичих (Нэг эхийг 	<ul style="list-style-type: none"> - Шалтгааны утгат угсарсан нийлмэл өгүүлбэр - Шалтгаан үрийн холбоо харьцаа бүхий төрөл бүрийн эхүүд

	<p>цогцолбороор хуваан тусгай цаасан дээр бичиж бэлтгэсэн байна.)</p> <ul style="list-style-type: none"> - Эхэд байгаа цогцолборуудын байр, дарааллыг сольж найруулан бичих (Холбох үг, нөхцөл өөрчлөгдөнө.) - Цогцолборуудыг холбон найруулахад холбох үг, нөхцөлүүдээс тохирохыг сонгох дасгал хийх (Үүний тулд өгүүлбэрийн түвшинд ийм дасгал хийж, дараа нь цогцолорын түвшинд хийж болно. <p>Эхийн санааг эрсэг болгон найруулах</p>	
<p>8.2д. Жишээ баримт ашиглан дүрслэн тайлбарласан эх зохиож бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Тогтвортой хөгжлийн асуудлыг сонгох - Өөрсдийн нутаг орон, орчин тойрны ховордсон ан амьтны мэдээлэл цуглуулах - Тэдгээрийн тухай өөрсдийн мэддэг зүйлээ бичих - Эхэд аль болох олон янзын баримт ашиглаж бичих - Зохион бичих төлөвлөгөө гаргах - Бичих сэдвийн хүрээнд, ном, сурах бичиг, сонин, сэтгүүл, толь бичиг, интернэтийн мэдээллийн сангаас уншиж мэдээлэл цуглуулах - Радио сонсох, телевизийн нэвтрүүлэг үзэх, мэдэх хүнээс асууж ярилцах зэргээр баримт мэдээлэл цуглуулах төрөл бүрийн арга хэрэглэх - Баримт мэдээллийг товч тэмдэглэх, бүдүүвч зургаар тэмдэглэх - Баримт мэдээллийг ангилж бүлэглэх - Баримтыг шинжлэх, нэгтгэн дүгнэх - Ерөнхий мэдээлэл, дэмжих баримтыг тохируулан сонгох - Чухал баримтыг сонгох - Оюуны зураглал хийх - Баримт мэдээллийг өөрийн сэтгэгдэл, уран дүрслэл, хэлц зэргээр баяжуулан дүрслэн тайлбарлаж бичих - Уран дүрслэл бүхий үг хэллэг ашиглан тайлбарлах - Зөв бичгийн дүрэм болон найруулгын алдааг хянах 	<ul style="list-style-type: none"> - Ховордсон ан амьтдыг хайрлан хамгаалах тухай баримтад тулгуурласан эх - Мазаалайн тухай баримтууд - Ж.Мягмарсүрэн “Халамцуухан мазаалай”
<p>8.2.е Өөрийн болон бусдын зохиосон эхийг хянан шинжилж, найруулгыг засан сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Бусдын бичсэн эхийг сонгох - Өөрийн бичсэнийг амжилтын шалгуураар үнэлэх - Анги, бүлэг дотор бичсэн эхээ солилцох - Хосоор ажиллах - Эхийг хянах шалгуур гаргах - “Бод, хамтар, хуваалц” аргаар бусдын бичсэнийг хянах шалгуур гаргах 	<ul style="list-style-type: none"> - Сурагчийн бичсэн эх - Зөв бичих дүрэм - Жишээ өгүүлбэр, үг

	<ul style="list-style-type: none"> - Ангийн хананд байрлуулах - Найруулгыг хянахад зориулж өгүүлбэрийн жишээ гаргах - Найруулгын алдааг баримтаар тайлбарлах - Нотлох, батлах - Багаараа хамтран дүгнэлт гаргах - Жишээ баримтыг дүрмээр батлах - Залруулах, хөрвүүлэх 	
<p>8.1ж. Зохион найруулсан эхээс баримтын учир зүйн холбох үгийг буруу хэрэглэсэн алдааг таньж, найруулгыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Баримтын болон учир зүйн алдаа гаргасан өгүүлбэр болон алдаагүй өгүүлбэрийг харьцуулан унших - Баримтын болон учир зүйн алдааг ялган таних - Баримтын болон учирзүйн алдаатай нийлмэл өгүүлбэр болон цогцолбор бичил эх унших - Эхээс найруулгын алдааг олж, тайлбарлах - Засаж найруулж бичих - Холбоос үгийг оновчгүй хэрэглэсэн алдаа бүхий өгүүлбэр унших - Өгүүлбэрт найруулгын ямар алдаа байгааг илрүүлэх - Алдаатай өгүүлбэрийг засан найруулж бичээд, тайлбарлах - Тухайн холбоос үгстэй ойролцоо утгатай өөр ямар холбоос үгээр найруулж болохыг ярилцах, олон хувилбар гаргах - Нийлмэл өгүүлбэрийг болон цогцолборуудыг холбоход холбоос үгийн сонголт чухал болох талаар ярилцах - Хэд хэдэн энгийн өгүүлбэрүүдийг холбоос ашиглан найруулж холбоос үгийн утгын талаар ярилцах - Найруулгын алдаатай эх уншиж, найруулгын алдааг олж, засан сайжруулах, өөрийн зассан үндэслэлээ тайлбарлах 	<ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн найруулгын алдаатай өгүүлбэр - Сонины найруулгын алдаа

ЯРИХ - СОНСОХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
	<ul style="list-style-type: none"> - Өөрийн цуглуулсан мэдээллээр ангийнхандаа товч яриа хийх - Бусдын яриаг анхааралтай сонсож, чухал гэж үзсэн хэсгээ тэмдэглэх 	<ul style="list-style-type: none"> - Зохиолчийн бичсэн үнэлэлт дүгнэлт бүхий эх - Уран зохиолын ба уран зохиолын эх

<p>8.3а. Сонсогчоо мэдэрч, оновчтой баримт, мэдээлэл ашиглан илтгэх</p>	<ul style="list-style-type: none"> - Тэмдэглэсэн чухал хэсгээ дэлгэрүүлэн ярихдаа харсан, сонссон, уншсан зүйлээсээ жишээ татан баримтаар дэлгэрүүлэн ярих - Үзэл бодлоо шингээн ярих - Яагаад тухайн сонгосон хэсгээ чухал гэж үзсэнээ тайлбарлах - Ярианаас чухал хэсгийг сонгож, түүний талаар лавшруулсан асуулт тавих - Бусад нөхдийнхөө чухал гэж сонгосон хэсэг өөрийнхтэй таарч байгаа эсэхийг тулгаж, ялгаатай санааг харьцуулан дүгнэлт гаргах - Ярьж буй сурагчийн чухал гэж бодсон санааг өөрийнхтэйгөө харьцуулах 	
<p>8.3б. Тогтвортой хөгжлийн сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлэн баталж нотолж тайлбарлан ярих</p>	<ul style="list-style-type: none"> - Ярих сэдэв, зорилгоо тодорхойлох - Өдөр тутмын амьдралд тохиолдож байгаа тулгамдсан асуудлыг жагсаан бичиж, тэдгээрээс хэлэлцүүлэг хийх сэдвээ сонгох. Жишээ нь: компьютер, гар утас, гялгар уут, батерей гэх мэт ашиг тустай боловч зохисгүй хэрэглэвэл хор нөлөө учруулах зүйлсээс сонгон түүний зохистой хэрэглээний талаар бичих) - <i>Тухайн сэдэвт хамаарах мэдээлэл, материал цуглуулах</i> - Тухайн сэдвийг аль талаас нь харж яриагаа бэлтгэхээс хамаараад мэдээллээ цуглуулна. - Өөрсдийн хэлэх гэж байгаа санааг батлах баримт, мэдээлэл, нотолгоог цуглуулах - Бусдад нөлөөлж чадах хамгийн чухал баримт нотолгоонуудаа ялгаж бүлэглэх, цэгцлэх - <i>Ярих бэлтгэл хийх</i> - Яриагаа эхлэх - Өөрийн санаа бодлоо бусдад хүлээн зөвшөөрүүлэхийн тулд цуглуулсан баримт нотолгоогоо ашиглах - Хэнд хандаж ярихаас шалтгаалж үгийн сонголт, ярианы өнгө аясаа тохируулах 	<ul style="list-style-type: none"> - Өсвөр үеийнхний цахим хэрэглээтэй холбоотой асуудлаар хэлэлцсэн эх - Сурагчдын чөлөөт цагийн тухай асуудал дэвшүүлсэн илтгэл - Байгаль хамгаалах сэдэвт эх

IX АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

Зорилго, зорилтын Энэхүү баримт бичиг нь есдүгээр ангид хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд нь багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой удирдамж болно.

Нэг талаас, суралцагч унших, ярих, бичих, ухаарах, эргэцүүлэх үйлийн үр дүнд санаа бодлоо ярианы болон бичгийн найруулгын зохих шаардлагын дагуу илэрхийлдэг болж гэмээнэ харилцахуйн болон суралцахуйн үйл ажиллагаанд эх хэлээ зөв зохистой ашиглаж, сурах арга барил эзэмшдэг, нөгөө талаас, танин мэдэх үйл ажиллагаа нь хэл, сэтгэхүйн харилцан хамаарлаар бүрэлдэн тогтдог гэсэн гол зарчимд тулгуурлан, хөтөлбөрийн агуулгыг сонгож, суралцахуйн зорилтыг тодорхойлсон болно. Сургалтын үндсэн нэгж нь сургах арга барил гэж үзвэл оюуны чанар нь мэдлэгт, оюуны арга барил нь чадварт, сурах арга барил нь дадал төлөвшилд тус тус хамаарна. Иймээс эх хэлний сургалтын гол зорилго нь юуны өмнө, уншсан, сонссоноо ухаарч ойлгох, хүртэж хүлээн авч эргэцүүлэн бодох чадвараас эхлээд, санаа бодол, мэдрэмж, сэтгэгдлээ ам ба бичгээр оновчтой илэрхийлэх чадвар, дадалтай болгох, улмаар эх хэл, өв соёлоо эрхэмлэн хүндэтгэх үзэл хандлага төлөвшүүлэхэд чиглэж байна.

Багш сургалтыг зохион байгуулахдаа суралцахуйг дэмжин, суралцагчдыг бүтээлчээр шинжлэн судлахад хөтөлнө. Сурагчид мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах арга барил эзэмшсэн байхаар арга, аргачлалыг боловсруулж хэрэглэнэ. Ийм санааг энэхүү зөвлөмжид тусгахдаа хичээлийн төлөвлөгөө болон эх задлах, эхийн утга санааг ухаарах, мэдээлэлтэй ажиллах, боловсруулах үйлээр жишиг болгон оруулав.

Хэлзүйн дүрэм, тодорхойлолт, нэр томъёог зааж таниулахдаа хэрэглээний чадвараас салангид үзэхгүй, харин сургалтын шинжлэх ухаанч чанарыг эрхэмлэн, мэдлэгийг үйлийн явцад өөрөө бүтээх, янз бүрийн орчинд турших, хэрэглэх бүтээлч үйлийн орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Суралцагч бүрийн онцлог, тэдний эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлагыг харгалзахын зэрэгцээ багш, суралцагчийн хамтын ажиллагаа, оролцоонд тулгуурлах, мэдээллийн олон эх үүсвэртэй ажиллах замаар суралцагч бүр өөрийгөө хөгжүүлэх, бие даан мэдлэг чадвараа нээн ажиллах боломжоор хангах, түүнчлэн суралцагчийн өөрийгөө илэрхийлж сурах хэрэгцээнд тулгуурлан, бичгийн болон ярианы чадварыг хөгжүүлэх, эх хэлнийхээ үнэт зүйлсээс тасралтгүй суралцах боломж бүрдүүлж, хэл ярианы болон харилцааны соёлд сургах зорилтыг чухалчлан үзнэ. Идэвхтэй сургалтын аргаар суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинэ санаа бүтээх, хувиргах, ургуулан бодох, үг хэллэгийн утгыг ухаарах, мэдрэх, сэтгэлгээний уян хатан чанар, урнаар сэтгэх зэрэг бүтээлч үйлд сургах нь эх хэлний сургалтаар шийдвэрлэвэл зохих суралцахуйн чухал зорилтууд болно. Баримтын эхийг уншиж, утга санааг бүрэн гүйцэд ухаарах, бүрдэл хэсгээр задлан шинжлэх, тайлбарлах, харьцуулах, зохиох, бүтээх, хувиргах зэрэг янз бүрийн дасгал даалгавар гүйцэтгэх дидактик зорилт нь суралцах чадвар, сурах арга барил, бүтээлчээр эрэлхийлэх, судлан шинжлэх арга барил эзэмших, бие даан суралцах үйлийг бүх талаар дэмжихэд чиглэнэ. Ингэх нь суурь боловсролын бодлого, зорилготой бүрнээ нийцэж байгаа болно.

Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго нь сурагч бүрт сурах арга барил, шинжлэх ухааны суурь мэдлэг чадвар эзэмшүүлэх, үндэсний хэл, түүх, соёлоо дээдэлдэг

хүмүүнлэг үзэл, хандлага төлөвшүүлэхэд чиглэнэ хэмээн тодорхойлсон тул сургалтыг зохион байгуулахад багш дараах зүйлийг анхаарвал зохилтой. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй нь багш, суралцагчдын хамтын үйлд суурилах учраас суралцагч бүрийн бүтээлч үйл ажиллагаа, оролцоонд тулгуурлан, үйлийн явцад суралцах нөхцөлийг бүрдүүлэх;
- Суралцагчдад шинжлэн судлах арга барил эзэмшүүлэхэд чиглэсэн байх; эхийг задлан шинжлэх үйлийн явцад бүтээлчээр эрэл хайгуул хийх, шинжлэн судлах арга барилыг тодорхой үе шаттай, алхам дарааллаар эзэмших боломжийг бүрдүүлэх;
- Суралцагчдад эргэцүүлэн бодох, сэтгэх, бодол санаа, мэдрэмжээ илэрхийлэх, аливаа зүйлийг судлах сонирхол, эрмэлзлийг өдөөхүйц идэвхтэй сургалтын аргыг хэрэглэх;
- Сурах үйл ажиллагааг суралцагч өөрийгөө танин мэдэхэд чиглүүлэн удирдан зохион байгуулах, сурах үйлд ухамсартай, бүтээлч, хариуцлагатай ханддаг болох үзэл хандлагыг төлөвшүүлэх, дэмжих;
- Шинжлэн судлах арга барилыг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтын хэрэглэгдэхүүн болох ажлын хуудас, дасгал, даалгаврыг олон хувилбараар боловсруулж ашиглахаас гадна түүхийн болон мэдээллийн олон эх сурвалж, урлагийн бүтээл зэргийг оновчтой сонгон хэрэглэх;

Эдгээр нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлийн орчин төдийгүй орчин үеийн сургалтын нийтлэг шаардлага болж байна.

УНШИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>9.1а. Уншигчийн захидал, шүүмж зэрэг асуудал дэвшүүлэн тайлбарласан, учир шалтгааныг тайлбарласан, таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних</p>	<ul style="list-style-type: none"> - Эхийг бүхэлд нь гүйлгэн унших, чухал хэсгийг сонгон уншин, бүхэлдээ юуны тухай өгүүлж байгааг ерөнхийлөн баримжаалах - Эхийн цогцолборуудыг ялгах - Эхийн цогцолборуудын холбоосыг тодруулах - Эхийн цогцолборуудын түлхүүр үгсийг тодорхойлох - Өгүүлэгдэж буй юмс тэдгээрийн харьцаа холбоог олох - Цогцолборуудыг түлхүүр үгсээр холбосныг тодорхойлох - Эхэд юуны тухай, ямар асуудал дэвшүүлснийг тодорхойлох - Эхийн гол санаа болон гарчгийн уялдаа холбоог тодорхой тайлбарлан үзэл бодлоо илэрхийлэх, - Зохиогчийн зорилгыг тодорхойлсон тайлбар гаргах - Эхэд юуны тухай өгүүлж байгааг тодорхой тайлбарлахдаа уул эхээс жишээ татах - Эхийн гол санааг тодорхойлохдоо түүнийг дэмжиж буй мэдээллүүдийг ялгаж илрүүлэх, - Мэдээллүүд нь эхийн гол утга санааг хэрхэн баяжуулж байгааг тодруулах: Тухайлбал, асуудал дэвшүүлсэн эхэд гол утга санааг тодруулах явцдаа зохиогч дэвшүүлсэн асуудлаа нотлохын тулд ашигласан дэмжигч мэдээллүүдийг тодруулж унших - Өгүүлэгчийн үзэл бодол, нотолгоо баталгааг ялгаж тайлбарлах, эхийг товчилж хураангуйлах - Эхийн агуулгыг баримт мэдээлэл, зохиогчийн үзэл бодол гэсэн хэсэгт ялган ангилж унших - Эхээс чухал ба чухал бус мэдээллийг ялгах, ангилах - Эхийн үйл явдал, зохиогчийн үзэл бодол, хэлэх гэсэн санаа зэргийг эхэд хэрхэн байрлуулсан ерөнхий бүтцийг тайлбарлах (харьцуулсан, шалтгаан болон үр дүн, асуудал болон шийдэл, цаг хугацааны дараалал гэх мэт) - Эхийн гол санаа болон гарчгийн уялдаа холбоог тодорхой тайлбарлан үзэл бодлоо илэрхийлэх, - Зохиогчийн зорилгыг тодорхойлсон тайлбар гаргах - Эхэд юуны тухай өгүүлж байгааг тодорхой тайлбарлахдаа уул эхээс жишээ татах 	<ul style="list-style-type: none"> - Учир шалтгааны болон таамаглал дэвшүүлэн тайлбарласан эх - Уншигчийн захидал - Шүүмж - Сонины өгүүлэл, илтгэл мэдээлэл зэрэг нийтлэлийн эхүүд - Д.Баттогтох “Эсээ бичих эрдэм” УБ., 2006 - Ж.Бат – Ирээдүй “Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат үг хэллэгийн толь бичиг” УБ., 2006 - МУ – ын ШУА “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” УБ., 2008

	<ul style="list-style-type: none"> - Эхийн гол санааг тодорхойлохдоо түүнийг дэмжиж буй мэдээллүүдийг ялгаж илрүүлэх - Мэдээллүүд нь эхийн гол утга санааг хэрхэн баяжуулж байгааг тодруулах: Тухайлбал: Учир шалтгааны эхэд гол утга санааг тодруулах явцдаа зохиогч дэвшүүлсэн асуудлаа нотлохын тулд ашигласан дэмжигч мэдээллүүдийг тодруулж унших - Өгүүлэгчийн үзэл бодол, нотолгоо баталгааг дэмжиж буй мэдээллүүдийг ялгаж тайлбарлах, эхийг товчилж хураангуйлах - Эхийн доторх үгсийн ил ба далд утгыг ойлгох, тайлбарлах - Эхийн өвөрмөц шинжийг илэрхийлсэн жишээг олж тодорхойлох, тэмдэглэх, үр дүнг нэгтгэх, хэлэлцэх - Эхээс сурагчдын амьдралын орчин, нийгмийн тулгамдсан асуудалтай холбоо бүхий хэсгүүд, ямар нэг асуудал байж болох хэсгүүдийг ялган тодруулах, ангилах 	
<p>9.16. Учир шалтгааныг тайлбарласан, таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Дэвшүүлсэн асуудлыг гол санаагаараа хэрхэн илэрхийлж гаргасан буюу эхийн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог тодруулах - Эхийн агуулгыг хэдэн хэсэгт хувааж болохыг тогтоох, шинжлэх - Эхийн агуулгыг баримт мэдээлэл, зохиогчийн үзэл бодол гэсэн хэсэгт ялган ангилж унших - Эхээс чухал ба чухал бус мэдээллийг ялгах, ангилах - Эхийн үйл явдал, зохиогчийн үзэл бодол, хэлэх гэсэн санаа зэргийг эхэд хэрхэн байрлуулсан ерөнхий бүтцийг тайлбарлах (харьцуулсан, шалтгаан болон үр дүн, асуудал болон шийдэл, цаг хугацааны дараалал гэх мэт) Тухайлбал: Тайлбарлаж уншихдаа төлөвлөгөөний аргыг хэрэглэж болно. Уншиж тэмдэглэл хийж сурахад чиглэсэн хэд хэдэн үе шатаар хэрэгжих арга бөгөөд сурагчид уншихын өмнө эсвэл унших явцдаа бодож тэмдэглэж уншина. 1. Уншихын өмнө эх бичвэрийн агуулгыг таамаглах тэмдэглэл хөтлөх 2. Мэддэг болон мэддэггүйгээр ялгаж тэмдэглэж унших - Хоёр ба түүнээс дээш эхийг харьцуулан унших замаар баримт ба сэтгэгдэл мэдрэмжийн ялгааг тодруулж тайлбарлах - Зохиогч санаагаа илэрхийлэхийн тулд ашигласан баримт нь түүний үзэл бодлоос ялгаатай болохыг ойлгох - Сэтгэгдэл мэдрэмж нь баримтаас яагаад ялгаатай болохыг тодруулж тайлбарлах - Эхийн хэсэгт дүгнэлт хэсэг чухал болохыг ойлгох. 	<ul style="list-style-type: none"> - Таамаглан тайлбарласан эх - Уншигчийн захидал - Шүүмж зэрэг нийтлэлийн эхүүд - ШУТ – ийн ИС, Гадаад хэлний институт, Монгол судлалын тэнхим “Хэл ярианы соёл” УБ 2014, “Зөв дуудах хэм хэмжээ, зөв бичих хэм хэмжээ, хэл зүйн хэм хэмжээ, үгийн сангийн хэм хэмжээ” 19 – 20 дугаар тал

	<ul style="list-style-type: none"> - Эхийн хэсгүүдийг ангилан ялгах, ганцаарчлан бодох, хосоор ажиллах, багаар саналаа нэгтгэх. Тухайлбал: “Бодох, хамтрах, хуваалцах” аргыг хэрэглэж болно. - Эхэд дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлтийг олж, тайлбарлах - Эхийн холбоосуудыг олж “Дэвшүүлсэн асуудал, тайлбар, үзэл бодол, дүгнэлт” -ийн холбоо хамааралд ямар үүрэгтэйг тайлбарлах <p>Таамаглан тайлбарласан эхийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> - Баримт, үзэл бодлыг ялгаж унших - Таамаглал агуулсан хэсгийг ялгах, тодорхойлох - Үгүйсгэсэн, баталсан хэсгийг тодорхойлох - Таамагласан, үгүйсгэсэн, баталсан утгат үг хэллэгийг ялган тодруулах - Эхийг уншихдаа зураг дүрслэл гэх мэттэй харьцуулан ажиглаж унших - Зохиогчийн хэрэглэсэн баймж утгат үг хэллэгийг тайлбарлах - Үндэслэл бүхий тайлбаруудыг ялгаж унших - Ил хэлээгүй боловч эхийн утга агуулгаар дамжуулан илэрхийлсэн далд утгат дүрслэлийг мэдэрч унших - Таамаглал дэвшүүлж бичихийн тулд өөрт хэрэгцээтэй мэдээллийг ялган тодруулж унших учир шалтгааныг таамаглан тайлбарлах 	
<p>9.1в. Зохиогчийн үзэл бодол, мэдрэмж сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг дэвшүүлсэн асуудал, дүгнэлт өгүүлбэрийн уялдаа холбоо, баймж нэгжүүдээр тодорхойлж тайлбарлах</p>		
	<p>Тайлбарласан эхийн агуулгыг баримт - үзэл бодол, шалтгаан - үр дагавар, таамаглал</p>	

<p>9.1г. Тайлбарласан эхийн агуулгыг баримт - үзэл бодол, шалтгаан - үр дагавар, таамаглал, баталгаа нотолгооны холбоо хамаарлаар ялган тодруулах</p>	<p>дэвшүүлэн баталж нотолсон хэсгийн холбоо хамаарлаар ялган тодруулахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Эхийг бүхэлд нь гүйлгэн унших, хэсэгчлэн унших - Дэвшүүлсэн асуудлыг тодорхойлох - Уг асуудлын шалтгааныг тодруулах - Шалтгаан, үрийн харьцааг гаргахад хэрэглэсэн үг бүтээвэр гэх мэт хэлний нэгжүүдийг ажиглах, утга, үүргээр ангилах. Тухайлбал: ... аас болж, ... ээс,тул, учир гэх мэт холбох үг, бүтээврийг шалтгаан үрийн холбоог гаргахад хэрхэн ашигласан, яагаад ашигласныг анхаарна. - Эхээс учир шалтгааны утгат хэсгүүдийг тодруулагч харандаа, эсвэл хайч ашиглан хэсэглэх, хураах гэх мэт аргыг ашиглах - Эхийн агуулгыг хураах замаар шалтгаан үрийн харьцааг тодруулах 	<ul style="list-style-type: none"> - Байгаль хамгаалах сэдэвт учир шалтгааныг тайлбарласан эхүүд - Нийгмийн асуудлыг хөндсөн учир шалтгааныг тайлбарласан эхүүд - Нийтлэл
<p>9.1д. Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл болон орон, цаг, зорилго, шалтгааны утгат угсруулан холбох үг бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлах, тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> - Эх ба өгүүлбэрийн холбох баймж нэгжийг олох - Эхийн дотоод зүй тогтлын учир шалтгааныг эрэлхийлэх - Нэр томъёог тайлбарлах - Эхийн хэв маягийг тодорхойлох, угсруулан холбох үг, бүтээврийн онцлогийг эхийн хэв маягтай холбон тайлбарлах - Таамаглан тайлбарласан эхийн үгүйсгэсэн, баталсан, таамагласан хэсгийг тодорхойлох - Таамагласан, үгүйсгэсэн, баталсан утгат үг хэллэгийг ялган тодруулах, баймж нэгж нь өгүүлбэрийн утгыг нэмэн дэлгэрүүлэх, уншигчийн сонирхлыг татахад хэрхэн нөлөөлдгийг тодруулах - Эхээс баймж нэгжүүдийг тодруулж унших, утгын ялгааг тайлбарлах - Эх ба өгүүлбэрт баймж нэгжийг хэрэглэсэн, хэрэглээгүй жишээг харьцуулан ажиглах 	<ul style="list-style-type: none"> - Эх хэл, шинжлэх ухаан танин мэдэхүй, түүх соёлын сэдэвт таамаглал дэвшүүлсэн эхүүд - Асуудал дэвшүүлсэн нийтлэл эх
<p>9.1е. Өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг харьцуулан дүгнэх</p>	<ul style="list-style-type: none"> - Эхийг бүхэлд нь гүйлгэн унших, хэсэгчлэн унших, мэдэхгүй үгсийн утгыг тайлбарлах - Хам сэдвийн доторх мэргэжлийн үг, нэр томъёо зэрэг үг хэллэгийн илэрхийлэх утгын жагсаалт гаргах - Хам сэдвийн хүрээнд үгсийн утгыг эргэцүүлэн бодох, үгийн утгыг тайлахын тулд толь бичиг ашиглах, өөрсдийн тайлбартай харьцуулах - Үгийн сангийн утга, хам сэдвийн утгын ялгааг харьцуулах, тайлбарлах - Эхийн доторх мэргэжлийн үг хэллэг, нэр томъёо гэх мэтийг ялган тодруулах - Төрөл бүрийн мэргэжлийн үг хэллэг бүхий эхийг харьцуулан унших - Утгыг ялгаж мэдэх, мэдэхгүйгээр нь ангилан ялгах 	<ul style="list-style-type: none"> - Түүхэн сэдэвт түүхийн хам сэдвийн үүднээс тайлбарлах үг хэллэг бүхий эх - Асуудал дэвшүүлсэн эх

	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн үг хэллэгийг тайлбарлах, илүү өргөжүүлэн мэдэхийн тулд толь бичиг ашиглах - Мэргэжлийн шинжтэй үг хэллэгийн хувьд тухайн эх дээр илэрхийлж байгаа утга болон өөр бусад утгыг гаргах, үүний тулд хэд хэдэн толь бичиг харьцуулан үзэх - Эхэд байгаа мэргэжлийн үг хэллэгээс үүдэн зохиогчийн мэргэжил, эхийг бичсэн зорилго, цаг хугацааг хам сэдвийн үүднээс тодорхойлох - Эхэд хэрэглэсэн мэргэжлийн үг хэллэгээс үүдэн эхийн агуулгыг ерөнхийд нь ойлгох, цаашлаад нарийвчлан ойлгох чадвартай болох - Мэргэжлийн үг, нэр томъёо тус бүрийг эхийн хэсэг тус бүрээр ялган авч үзэх, утгыг хэлэлцэх, толь ашиглаж утгыг тодруулах, тухайн эхэд ямар үүрэгтэй орсон талаар дүгнэх 	
--	---	--

БИЧИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>9.2а. Асуудал дэвшүүлэн таамаглаж бичихдээ баталж нотолж, үгүйсгэж бичих</p>	<p>Асуудал дэвшүүлэн таамаглаж, баталж нотолж, үгүйсгэж бичих замаар үзэл бодлоо илэрхийлж бичихийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Эхээс таамагласан, баталж нотолсон, үгүйсгэсэн утгатай хэсгийг ялгаж унших, хэсгээр ялгах, ялгаж тодруулах - Бичил эхийн хувьд ялгаж бичих, хэлэлцэх - Цогцолбороос эдгээр баймж утгатай үг, өгүүлбэрийг ялган тодруулах, хэлэлцэх - Таамаглал дэвшүүлэх аргад суралцах - Асуудлаа дэвшүүлэхийн тулд эрэл хайгуул хийх, сэдвээ тодорхойлох, баримт мэдээлэл цуглуулах, - Мэдээллийг чухал чухал бишээр нь ангилан ялгах, анализ дүн шинжилгээ хийх - Таамаглал дэвшүүлэх бичих хамгийн оновчтой шалтгаанаа эрэл хайгуул хийж олсон баримтуудаас тодруулах - Баримтуудаас холбоотой мэдээллийг ойролцоо ба эсрэг утгаар ялган бүлэглэх, хэрэгцээтэй мэдээллийг ялгах - Төлөвлөгөө зохиох, оюуны шуурга хийж бичих, санаагаа цэгцлэх, санаагаа зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> - Асуудал дэвшүүлэн тайлбарласан эх - Таамаглал дэвшүүлсэн, учир шалтгааныг тайлбарласан эх - Шүүмж, уншигчийн захидал зэрэг нийтлэл эх

<p>9.26. Байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр асуудал дэвшүүлэн, шалтгаан үр дагаврын холбоог гаргаж бичих</p>	<p>Байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлэн, санаа бодлоо үндэслэлтэй илэрхийлж, шалтгаан үр дагаврын холбоог гаргаж бичихийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Төрөл бүрийн эх сурвалжаас байгаль, нийгмийн сэдвээр эрэл хайгуул хийх, унших, судлах, бичих зорилго, уншигчаа тодорхойлох - Илэрхийлэх гэж байгаа утга, эхийн сэдвийг тодорхой болгохын тулд судалгаа хийх, хэлэлцэх - Сэдвээ сонгож хүрээ хязгаараа тогтоох - Эхийг ямар хэв маягаар бичихээ тодорхойлох - Мэдээлэл цуглуулах, эрэмбэлэн цэгцлэх - Эхийн сэдэв, дэд сэдвийг тогтоох - Яагаад, хэнд зориулж, ямар гол санаа илэрхийлснийг тогтоох - Асуудлыг шийдвэрлэхийн тулд эсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч бичих маягаар учир шалтгааны уялдаа холбоог илэрхийлж бичих. Үүний тулд асуудлыг хоёр талаас судалж үзсэн байх - Учир шалтгаан ба үр нөлөөний хоорондын уялдаа холбоог төрөл бүрийн жишээн дээр судалж үзэх - Шалтгаан үрийн холбоо бүхий баримт мэдээлэл цуглуулах - Мэдээллийг эрэмбэлэх, ангилах, ялгах, хамтран ажиллах, хэлэлцэх - Төлөвлөгөө зохиох, амжилтын шалгуураа тодорхойлох - Төлөвлөгөөний дагуу мэдээллийг эрэмбэлэх, цэгцлэх - Ноороглох, санаагаа зохион байгуулах, зохиож бичих, засаж сайжруулах 	<ul style="list-style-type: none"> - Байгаль, нийгмийн сэдвээр асуудал дэвшүүлсэн төрөл бүрийн нийтлэл эх - Монгол хэл, бичиг уран зохиол. Багшийн ном IX анги. УБ., 2015
<p>9.2в. Асуудал дэвшүүлэн тайлбар, үзэл бодол, дүгнэлтийг уялдаа холбоотой илэрхийлж бичих</p>	<p>Асуудал дэвшүүлэн тайлбарласан эхийн баримт мэдээллийн учир шалтгааныг тодруулах, эргэцүүлэн тайлбарлах, дүгнэхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Үйл явдлын учир шалтгааныг тодруулж унших - Эхээс шалтгаан үрийн харьцааг загварчлах - Учир шалтгааныг илэрхийлэхэд хэрэглэсэн зохиогчийн үг хэллэгийг ялгах - Асуудал дэвшүүлэх аргыг тодорхойлох - Асуудлын шалтгааныг олох - Баримт мэдээллийг чухал ба чухал бусаар ялгах - Эхийн эерэг ба сөрөг үр дагаврыг тодорхойлох <ul style="list-style-type: none"> - Зохиогчийн үзэл бодол, баримт мэдээллийг ялгах 	<ul style="list-style-type: none"> - “Ном уншихын ач тус” сэдэвт баримт, мэргэн үгс, зүйр үгс, афоризм - Бодит амьдралын түүх - Нийтлэл эх

	<ul style="list-style-type: none"> - Дэвшүүлсэн асуудал, шалтгаан – үр, баримт – үзэл бодлын холбоо харьцааг илэрхийлэх аргыг тодорхойлох 	
<p>9.2г. Ойролцоо ба эсрэг ойлголтыг жишиж харьцуулан дүгнэх, учир шалтгааныг тайлбарлан бичихдээ тохирох холбоосоор холбон найруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Таамаглал дэвшүүлэхээр зорьж буй асуудал, асуултыг олох - Бичих зорилго уншигчаа тодорхойлох - Юуг тайлбарлахаа олж тогтоох - Ойролцоо ба эсрэг ойлголтыг харьцуулах, жиших - Мэдээлэл цуглуулах - Мэдээллээ задлан шинжилж, харьцуулах - Баримт мэдээлэлд тулгуурлан оновчтой, учир шалтгаантай байж болох таамаглалыг илрүүлэх - Баймж нэгжүүдийн утгын ялгааг тодруулах - Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат нэгжүүдийг утгаар ялгах - Төрөл бүрийн баймж үгсээс оновчтой сонгон хэрэглэх - Эхийг хувиргах - Таамаглан дүгнэхдээ хэлний нэгжүүдээс оновчтой сонгох - Өгүүлбэрийг тайлбарлах, хураах, дэлгэрүүлэх зэргээр хувиргах 	<ul style="list-style-type: none"> - Таамаглал дэвшүүлсэн шинжлэх ухаан, танин мэдэхүйн эх - Хэл, соёлын тухай баримтад тулгуурлан бичсэн эх, өгүүлбэр
<p>9.2д. Орон, цаг, зорилго, шалтгааны утгат холбох, үг, нөхцөл ашиглан угсарсан нийлмэл өгүүлбэрийг зохион найруулж бичих</p>	<p>Угсарсан нийлмэл өгүүлбэрийг зохион бичихдээ, угсруулан холбох, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл ашиглан найруулахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Уншиж судалсан мэдээлэл болон өөрийн үзэл бодлыг холбож бичихдээ учир шалтгааны холбоосуудыг оновчтой хэрэглэх - Үүний тулд төрөл бүрийн энгийн өгүүлбэрийг утгын ялгаатай холбоосоор холбон найруулах дадлага дасгал хийх. Жишээ нь: Тодорхой үг хэллэг, холбоосуудыг ашиглан тухайн сэдвийг мэдээлэх эсвэл тайлбарлах - Өөрийн санаа бодол түүний шалтгааныг холбохдоо тохирох үг хэллэг холбоос ашиглах (иймээс, ялангуяа, ингэж г.м.) - Энгийн өгүүлбэрийг учир шалтгааны холбоосоор холбон төрөл бүрийн аргаар дэлгэрүүлэх. Жишээ нь: “Хүн гэртээ төрж өссөн хулганыг үзэн ядаж хөөдөг. Харь гаднын муурыг залан авчирч элдэв сайхан хоол ундаар тэжээн буйлуулдаг.” гэсэн эсрэг утгат хоёр өгүүлбэрийг “мөртлөө” гэсэн холбоосоор холбон түүнээс учир шалтгааны дүгнэлт гаргахдаа “Яагаад гэвэл” гэсэн холбоосыг ашиглажээ. - Хэлний нэгжид төрөл бүрийн хувиргал хийх замаар холбох үгийн утгыг тодруулах - Нэг өгүүлбэрийг төрөл бүрийн утгатай холбоос үг бүхий өгүүлбэрээр дэлгэрүүлэх: 	<ul style="list-style-type: none"> - Шалтгаан үрийн холбоо бүхий асуудал дэвшүүлсэн эх - Шалтгааны утгат төрөл бүрийн угсарсан нийлмэл өгүүлбэрүүд - Б. Пүрэв – Очир “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй” УБ., 1997. 314 – 318 дугаар тал “ Байц гишүүн өгүүлбэр”

	<ul style="list-style-type: none"> - Өмнөх өгүүлбэрт дурдсан санаагаа дараагийн өгүүлбэрт эсрэгцүүлэхийн тулд, эсвэл лавшруулахын тулд төрөл бүрийн холбоосыг хэрэглэж сурах. Үлгэрлэвэл: Эх хэлний тухай хууль энэ онд батлагдсан. Гэвч Ийм учраасҮүний үр дүндӨөрөөр хэлбэл - Өгүүлбэр зохиосны дараа тухайн холбоос нь ямар утга санаа илэрхийлж байгааг тайлбарлах - Өгүүлбэрүүдийг холбоосыг өөр хооронд сольж, гарч буй өөрчлөлт дээр тулгуурлан дүгнэлт хийх - Эдгээр холбоосыг өөр өөр жишээ өгүүлбэр дээр солин найруулах - Сурагчид бие дааж холбоосыг хэрэглэх, өгүүлбэр зохиох - Эхээс учир шалтгааны утгат хэсгүүдийг тодруулагч харандаа, эсвэл хайч ашиглан хэсэглэх, хураах гэх мэт аргыг ашиглаж болно. - Эхийн агуулгыг хураах замаар шалтгаан үрийн харьцааг тодруулах 	
<p>9.2е. Баримтад үндэслэн тайлбарлан бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Тайлбарлах гэж буй зүйлээ таньж тогтоох - Баримт мэдээллийг ангилан ялгах дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах - Тайлбарлахыг хүсэж байгаа буюу дэвшүүлэх асуудлаа шийдэх - Баримт мэдээллийг ангилан ялгах дүн шинжилгээ хийх. Тухайлбал: Багшийн тараасан картыг сурагчид эрэмбэлэн, ангилан ялгана. Энэ нь таамаглан тайлбарлах гэж байгаа зүйлээ таньж тогтоох зорилготой. - Баримт мэдээллүүдийг харьцуулж, ойролцоо эсвэл ялгаатай, эсрэг тэсрэг талуудыг ажиглан зөвлөлдөх - Юугаараа ойролцоо, юугаараа ялгаатай байгаа хэв маягуудыг таньж тогтоох - Таамаглал дэвшүүлэхэд хамгийн ойр байж болох шалтгаануудыг багаараа ярилцаж гарах - Эцсийн шийдлээ гаргах. Анги нийтээрээ хэлэлцэн, таамаглал дэвшүүлэн тайлбарлах гэж сонгосон асуудал дээрээ тогтох уу, эсвэл хэрэгсэхгүй болгож өөр санаа дэвшүүлэх үү гэдгээ шийдвэрлэх - Тус бүрдээ эх бичихэд хэрэгцээтэй, сэдэвтэй холбоотой нэг нэг жишээг өөрийн амьдралын туршлагаас эсвэл зохиомол биш олны мэддэг ном зохиол, түүхэн үйл явдал, дэлхийн шинжлэх ухааны мэдээллээс олж багшийн бэлтгэсэнтэй адил картын хэлбэрээр бэлтгэх. Түүнийг 	<ul style="list-style-type: none"> - Учир шалтгааны болон таамаглал дэвшүүлэн тайлбарласан эх - Уншигчийн захидал - Шүүмж - Сонины өгүүлэл, илтгэл мэдээлэл зэрэг нийтлэлийн эхүүд - Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүй” УБ., 2008, Найруулгын алдаа түүнийг ангилах нь, 188 – 209 дүгээр тал

	эсээ бичихийн өмнө баримт мэдээлэл цэгцлэх аргаар цэгцлэх	
<p>9.2ж. Тайлбарласан эх, өгүүлбэрээс үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн, үг, өгүүлбэрийг буруу холбосон, буруу байрлуулсан зэрэг алдааг таньж, найруулгыг сайжруулах</p>	<p>Тайлбарласан эх, өгүүлбэрээс үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн, үг, өгүүлбэрийг буруу холбосон, буруу байрлуулсан зэрэг алдааг таньж, залруулж бичих, дүгнэлт хийхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Найруулгын алдааг таних - Үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн, үг, өгүүлбэрийг буруу холбосон, буруу байрлуулсан зэрэг найруулгын алдааг ялгах, тодруулах - Эдгээрийн шалтгааныг тодруулах, тайлбарлах - Оновчтойг сонгон хэрэглэх, алдааг сийрүүлэх - Ойролцоо үг хэллэгийг сонгон учрыг тайлбарлах - Шинээр зохиох <p>Өөрийн болон бусдын зохиосон тайлбарламж эхийг хянан шинжилж, алдааг таньж тайлбарлах, залруулахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Бусдын бичсэн эхийг, өөрийн үзэл бодолтой харьцуулан үнэлж дүгнэж ажиглах - Баримт мэдээллийг цуглуулах, ангилах, ялгах - Багаараа хэлэлцэн дэвшүүлсэн асуудалд тохирохыг ялгах - Хэрэгцээтэй мэдээллийг ангилах - Баримт мэдээллийг байрлуулахын тулд компьютер дээр ажиллах - Үнэлэлт дүгнэлтийг мэдээлэх болон ятгах зорилгоор бичих - Гол санааг дэлгэрүүлэх зорилгоор тэмдэглэл хөтлөх ба санаануудыг холбон найруулах - Төрөл бүрийн эх сурвалжаас өөрт хэрэгтэй мэдээлэл, үг хэллэгийн хэрэглээг тэмдэглэж авах - Зарим эхийн хэсгийг сонсоод түүнд үнэлгээ дүгнэлт өгч бичих - Үнэлэлт дүгнэлтийг шүүмж маягаар бичих - Аливаа асуудалд нухацтай өөрийн гэсэн бодолтой хандахад чиглүүлэн бичгээр асуух, асуултад бичгээр хариулах - Эхийн үйл явдлаас үүдэн, сайн муу, зөв бурууг тодорхойлох шийдвэр гаргах асуулт асууж хариулах, эхийн үйл явдлаас үүдэн дүгнэлт гаргахад чиглүүлсэн асуулт, эсвэл эхийн сургамжит үйл явдлаас үүдэн өөрийнхөө зан чанарт дүгнэлт хийхэд чиглүүлсэн асуулт, цаашлаад, эхийн гол гол ойлголтуудтай өөрийнхөө ойлголтыг харьцуулан шинээр дүгнэлт гаргах асуултын төрөл бүрийн хэлбэрийг ашиглах 	<ul style="list-style-type: none"> - Үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн, үг, өгүүлбэрийг буруу холбосон, буруу байрлуулсан зэрэг найруулгын алдаа бүхий өгүүлбэрүүд - Д.Отгонсүрэн “Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй” УБ., 1998 - Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүй” УБ., 2008, Найруулгын алдаа түүнийг ангилах нь, 188 – 209 дүгээр тал

	<ul style="list-style-type: none"> - Тодорхой зорилгоор эхийн утга учир дүр дүрслэлийг үнэлэх - Эхийг судалсны ач холбогдлыг мэдэх - Эхийн найруулгыг үнэлж дүгнэх, эх зохиох сонирхолтой болох - Өөрт төрсөн сэтгэгдэл, үнэлэмжээ илэрхийлэх 	
9.2з. Цэг цэглэлийг хэрэглэх	<p>Бүтээврийн нийлц, тэмдэг үсэг, цэг тэмдэг, утга ялгаж бичдэг үгсийг зөв бичихийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Эхийн доторх үгсийн зөв хэрэглээг ялгах - Үгсийг ажиглах, бүлэглэх - Дүрэмтэй холбон тайлбарлах - Учир начрыг олох - Алдааг залруулах, дүрмийг тайлбарлах 	<ul style="list-style-type: none"> - Зөв бичих дүрэм - Зөв бичих дүрмийн толь. УБ., 2018

СОНСОХ - ЯРИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
9.3а. Нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлаар баримтад үндэслэн, баталж, нотолж, үгүйсгэн үзэл бодлоо илэрхийлж мэтгэлцэх	<p>Нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлыг сонгосон сэдвийн хүрээнд ярихдаа, хэнд зориулж, ямар сэдвээр, хэрхэн ярьж таниулахаа шийдэж, төлөвлөхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Мэтгэлцээнд бэлтгэж дүрэм заавартай танилцах - Илтгэлийн тухай өмнөх ангид үзсэнээ сэргээн санах - Тулгамдсан асуудлыг эрэлхийлэх - Сургуулийн орчинд, үе тэнгийнхний хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг жагсаах - Яриагаа төлөвлөх - Нэг илтгэлд хэд хэдэн нотолгоог гаргаж чухлаас чухал бусаар нь эрэмбэлэн илтгэх дасгал хийх - Илтгэх чадвараа сайжруулах, уран илтгэх дасгал хийх, бичсэн илтгэлийг шууд уншихгүй, тэмдэглэл ашиглан илтгэх дасгал хийх - Сэдэв ба дэд сэдвээ тодорхойлох - Хэнд зориулж буйгаас шалтгаалан ярианы нөхцөл өөр болохыг ойлгох - Баримт хэрэглэгдэхүүнээ зорилгодоо тохируулан сонгох <p>Бусдын яриа танилцуулгыг сонсож ойлгох, асуулт асууж тодруулах, санал дүгнэлтээ хэлэхийн тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Мэтгэлцээнийг анхааралтай ажиглах - Тэмдэглэл хөтлөх, - Нотлох ба няцаах багаас асуух асуултын жагсаалт гаргах - Түлхүүр үгээр тэмдэглэх 	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн орчны тухай асуудал дэвшүүлсэн нийтлэл эх - Д.Отгонсүрэн “Ярианы найруулга, соёл” УБ., 1979 - Ц.Сүхбаатар “Яруу өгүүлэх чадвар” УБ., 2003 - Жефри А.Ричардс, Грейг С.Рикет “Мэтгэлцээнд суралцах нь”, Мэтгэлцэх чадвараа хөгжүүлэх нь УБ., 2001 - Боловсролын мэтгэлцээний төв “Мэтгэлцээнээр ертөнцийг таних нь”

	<ul style="list-style-type: none"> - Мэтгэлцээний үйл явцаас үүдэн, сайн муу, зөв бурууг тодорхойлох шийдвэр гаргах асуулт асууж хариулах - Үйл явцаас үүдэн дүгнэлт гаргахад чиглүүлсэн асуулт, лавшруулан тайлбарлахад зориулсан асуулт асуух, хариулах - Өөрийн санал дүгнэлтээ хэлэх - Мэтгэлцээний бэлтгэл хийх багаар хамтран ажиллах зохион байгуулалттай мэтгэлцээн, тухайн тохиолдлын мэтгэлцээний ялгааг тодруулах - Шийдэл гаргах (“Тийм” “Үгүй” гэсэн), судалгаа хийх - Асуудлыг хоёр талаас авч үзэх дасгал хийх, хосоор, багаар хамтран ажиллах - Эсрэг багаас ирж болох асуултын тохиолдлуудыг гаргах, кейс бичих, багаар ажиллах - Эсрэг нотолгоонуудын хувилбар бэлтгэх - Асуулт асуух, асуултад хариулах дасгал хийх (Урьдчилсан байдлаар ирж болох төрөл бүрийн асуултын хувилбаруудыг бэлтгэх, асуултад хариулах чиглэлээ гаргах) - Богино хугацаанд тодорхой төрөл бүрийн сэдвээр, товч оновчтой тэмдэглэл хөтлөх дасгал хийх (Мэтгэлцээний үед тодорхойлолт, шалгуур, нотолгоо, цаашдын няцаалт, хариулт гэх мэтийг богино хугацаанд хурдтай тэмдэглэх шаардлага гардаг.) - Солбисон асуулт, илтгэлийн гол санааг багаар хамтран гаргах - Лавлаж тодруулах асуулт асуух замаар харилцан яриаг өрнүүлж, байр суурийг нь хүндлэн, хувийн хандлага, мэдрэмжтэйгээ холбон үнэлж дүгнэх 	
--	--	--